



**ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ЯАМ**



**unicef**   
НҮБ-ын Хүүхдийн Сан

**“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ  
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ”  
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

Улаанбаатар хот  
2020 он

## ТАЛАРХАЛ

“Өмнөговь аймгийн өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндийн байдал” судалгааг Өмнөговь аймагт зохион байгуулахад өөрсдийн туршлага, санал бодлоо бидэнтэй хуваалцаж үнэтэй зөвлөгөө, санхүүгийн дэмжлэг харамгүй үзүүлсэн Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Суурин төлөөлөгч Алекс Хайкенс ба өсвөр үеийн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Болорчимэг нарт талархал илэрхийлье.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлдог Strengthen Difficulties Questionnaire (SDQ) асуумжийг ашиглан Өмнөговь аймгийн 15 сумдын эцэг эх, багш, хүүхдийг оролцуулсан судалгааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн Өмнөговь аймгийн ЗДТГ, ЭМГ, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ү.Энхцацрал, БСУГ-ын статистик, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Д.Цогтбаатар нар болон тэдний баг хамт олон, Аймгийн төв, сумдын ЕБС-ийн захиргаа, нийгмийн ажилтан, эмч, багш, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн удирдлага, НЭМЭШСГХ-СТСМТА-ны судлаач нартаа гүн талархал илэрхийлье.

## ХАМТРАН АЖИЛЛАСАН БАЙГУУЛЛАГА, ХАМТ ОЛОН

- Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сан
- Эрүүл мэндийн яам
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
- Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар
- Өмнөговь аймгийн Нийгмийн бодлогын хэлтэс
- Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар
- Өмнөговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар
- Өмнөговь аймгийн сэтгэц-наркологийн тасгийн хамт олон
- Өмнөговь аймгийн төв ба сумдын Ерөнхий боловсролын сургуулиудын захиргаа, багш, эмч, нийгмийн ажилтан нар
- Судалгаанд хамрагдсан сурагчид, багш, эцэг эх нар

## СУДАЛГААНЫ АЖЛЫН УДИРДАГЧ:

В.Баярмаа, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ

## СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗӨВЛӨХ:

Л.Насанцэнгэл, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ

## СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОХИЦУУЛАГЧ:

1. Н.Туяа, Анагаах ухааны магистр, дэд профессор, багш, СЭМТ, Ач АУИС
2. Б.Батцэцэг, Анагаах ухааны магистр, СЭМҮТ
3. Б.Нацагсүрэн, Анагаах ухааны магистр, СЭМҮТ

## **СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД:**

1. Даланзадгад сумын ЕБ-ын I сургуулийн судалгааны баг
2. Даланзадгад сумын ЕБ-ын “Эрдмийн гэгээ” сургуулийн судалгааны баг
3. Даланзадгад сумын ЕБ-ын III сургуулийн судалгааны баг
4. Даланзадгад сумын ЕБ-ын IV сургуулийн судалгааны баг
5. Даланзадгад сумын ЕБ-ын V сургуулийн судалгааны баг
6. Даланзадгад сумын ЕБ-ын VII сургуулийн судалгааны баг
7. Баян-Овоо сумын ЕБС-ийн судалгааны баг
8. Баяндалай сумын ЕБС-ийн судалгааны баг
9. Булган сумын ЕБС-ийн судалгааны баг
10. Гурвантэс сумын ЕБС-ийн судалгааны баг
11. Мандал-Овоо сумын ЕБС-ийн судалгааны баг
12. Манлай сумын ЕБС-ийн судалгааны баг
13. Ноён сумын ЕБС-ийн судалгааны баг
14. Номгон сумын ЕБС-ийн судалгааны баг
15. Сэврэй сумын ЕБС-ийн судалгааны баг
16. Ханбогд сумын ЕБ-ын I сургуулийн судалгааны баг
17. Ханбогд сумын ЕБ-ын II сургуулийн судалгааны баг
18. Ханхонгор сумын ЕБС-ийн судалгааны баг
19. Хүрмэн сумын ЕБС-ийн судалгааны баг
20. Цогт-Овоо сумын ЕБС-ийн судалгааны баг
21. Цогтцэций сумын ЕБС-ийн судалгааны баг
22. Цогтцэций сумын ЕБ-ын IV сургуулийн судалгааны баг

## **СУДАЛГААНЫ ТАЙЛАН БИЧСЭН:**

В.Баярмаа, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ

Т.Ганцэцэг, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМТ, АУС, АШУҮИС

## **АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН:**

Е.Гүлжанат, Анагаах ухааны магистр, СЭМҮТ

## **ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Л.Насанцэнгэл, Анагаах ухааны доктор (Ph.D), Профессор, СЭМҮТ

Б. Жаргал, Анагаах ухааны доктор (Ph.D), СЭМҮТ

## **ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН:**

Тоонот принтинг, 2020

## ГАРЧИГ

<b>ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ</b>	5
<b>ЗУРГИЙН ЖАГСААЛТ</b>	5
<b>ХУРААНГУЙ</b>	6
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ</b>	10
1.1 Судалгааны ажлын үндэслэл	10
1.2 Судалгааны ажлын зорилго, зорилтууд	11
1.3 Судалгааны ажлын шинэлэг тал	11
1.4 Судалгааны ажлын практик ач холбогдол	11
1.5 Судалгааны ажлын ёс зүй	11
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ</b>	13
2.1 Судалгааны загвар	13
2.2 Судалгааны хамрах хүрээ	13
2.3 Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн	13
2.4 Мэдээ материал цуглуулсан аргууд	20
2.5 Судалгааны үр дүнгийн боловсруулалт	20
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН</b>	21
3.1 Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүд	21
3.2 Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судалсан байдал	24
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭЛЦЭМЖ</b>	36
<b>ДҮГНЭЛТ</b>	36
<b>ЗӨВЛӨМЖ</b>	37
<b>НОМ ЗҮЙ</b>	39
<b>ХАВСРАЛТУУД</b>	40

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1	Судалгаанд баримталсан шалгуур үзүүлэлтүүд	13
Хүснэгт 2	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)	14
Хүснэгт 3	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)-ийн оноог тооцоолох нь	15
Хүснэгт 4	Өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн талаарх ойлголт	16
Хүснэгт 5	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)-ийн оноог хэвийн, зааг, хэвийн бус илрэлээр ангилсан нь	17
Хүснэгт 6	Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус илрэл	18
Хүснэгт 7	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)-ийн “Орчны нөлөөллийн нэмэлт оноо”-г тооцоолох нь	19
Хүснэгт 8	Өсвөр үеийнхний оршин суугаа харьяаллыг хүйс, анги, сурлагын дүнтэй нь харьцуулсан үзүүлэлт, тоо болон хувиар	21
Хүснэгт 9	Эцэг эх/асран хамгаалагчдын хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт, тоо болон хувиар	22
Хүснэгт 10	Багш нарын нас, мэргэжлээрээ ажилласан болон анги удирдсан жилийн дундаж оноог оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт	23
Хүснэгт 11	Багш нарын нас, мэргэжлээрээ ажилласан болон анги удирдсан жилийн дундаж оноог сумдаар харуулсан үзүүлэлт	23
Хүснэгт 12	Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлын дундаж оноог хүйсээр харьцуулсан үзүүлэлт	24
Хүснэгт 13	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлын дундаж оноог насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт	25
Хүснэгт 14	Эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээний дундаж оноог хүйс, оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт	26
Хүснэгт 15	Багшийн үнэлгээний дундаж оноог хүйс, оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт	27
Хүснэгт 16	Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус болон зааг илрэлүүд хувь хүн, нийгмийн амьдралд нь нөлөөлсөн байдал, тоо болон хувиар	29
Хүснэгт 17	Амиа хорлох эрсдэлийн талаарх багшийн үнэлгээг оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт, хувиар	33
Хүснэгт 18	Амиа хорлох эрсдэлийн талаарх эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээг оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт, хувиар	34
Хүснэгт 19	Амиа хорлох эрсдэлийн талаарх эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээг хүүхдийн хүйсээр харьцуулсан үзүүлэлт, хувиар	35

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1	“Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж”-ийн схем	16
Зураг 2	Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүд, хувиар	28
Зураг 3	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, үргэлжилсэн хугацаа (сар, жил), хувиар	30
Зураг 4	Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санааны байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг эцэг эх/асран хамгаалагч, багш, хүүхэд үнэлсэн үзүүлэлт, хувиар	31
Зураг 5	Амиа хорлох эрсдэлийг эцэг эх/асран хамгаалагч, багш үнэлсэн үзүүлэлт, хувиар	32

## ХУРААНГУЙ

### “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙДАЛ” СЭДЭВТ СУДАЛГАА

**Түлхүүр үг:** Сэтгэл хөдлөл, Өсвөр үеийнхэн, Сэтгэцийн эрүүл мэнд, Өсвөр үеийнхний зан үйл

**Үндэслэл:** Дэлхий дахинаа хүүхэд, өсвөр үеийнхний 20 хувь нь сэтгэц, зан үйлийн эмгэгтэй, сэтгэцийн ихэнх эмгэг хүүхэд, өсвөр насанд эхлэн илэрдэг гэсэн ДЭМБ-ын тооцоолол байдаг. Энэ асуудлыг илрүүлэх олон аргачлал байдаг ч сүүлийн үед “Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх асуумж” (Strengths and Difficulties Questionnaire-SDQ)-ийг өргөн хэрэглэж байна. ДЭМБ-ын (2006) Сэтгэцийн эрүүл мэндийн системийг үнэлэх тайланд (WHO-AIMS) “Монгол Улсад хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ алга” гэж дурдсан байдаг.<sup>10</sup> Иймээс бид сургуульд суурилсан сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийг эрт илрүүлж сэтгэцийн эмгэгтэй бие хүн болохоос урьдчилан сэргийлэх арга зүйг танилцуулах зорилгоор зонхилон тохиолдож буй сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгийг судлахаар зорьсон.

**Зорилго:** Өмнөговь аймгийн өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, тэдгээрийн тархалт, нөлөөлж буй зарим хүчин зүйлсийг судлан тогтооход оршино.

**Материал арга зүй:** Бид олон улсад түгээмэл хэрэглэдэг 25 асуулт бүхий “Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх асуумж-SDQ”-ийн эцэг эх, багш, хүүхэд гэсэн хувилбарыг сонгож, хувилбар тус бүрийн болон нийт онооны үзүүлэлтээр хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийг хэвийн, зааг, хэвийн бус илрэлээр ангилж судалсан. Судалгаанд агшингийн загварыг ашиглаж Өмнөговь аймгийн төвийн болон сумдын ЕБС-д суралцаж буй 11-18 насны 3788 хүүхэд, 3670 эцэг эх/асран хамгаалагч, 172 анги удирдсан багш нийт 7630 хүнийг хамруулж, 2019 оны 4-6 сарын хооронд явуулсан.

**Үр дүн:** Бидний судалгаанд аймгийн төвийн 1652 (43.6%), сумдаас 2136 (56.4%) нийт 3788 хүүхэд хамрагдсаны 46.8% (n=1774) нь хөвгүүд, 53.2% (n=2014) нь охид байсан бол судалгаанд хамрагдсан 3670 эцэг эх/асран хамгаалагчийн дундаж нас 40.1±9.1, хүйсийн хувьд 79.1% (n=2903) нь эмэгтэйчүүд, 20.9% (n=767) нь эрэгтэйчүүд байлаа. Судалгаанд нийт 172 багш хамрагдсаны дундаж нас нь 35.8±7.6, мэргэжлээрээ ажилласан дундаж жил 14.2±11.1, тухайн ангийг удирдаж ажилласан дундаж жил 2.46±1.6 тус тус байв.

Хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх “SDQ”-ийн асуумжаар эцэг эх/асран хамгаалагч болон багшийн үнэлгээний дундаж оноогоор хөвгүүд охидод нийтэч зан хэвийн илрэлтэй байсан. Анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх нь багш болон хүүхдүүдийн үнэлгээгээр хөвгүүд охидод хэвийн илрэлтэй байв.

Хүүхдүүдийн үнэлгээгээр хөвгүүд охидод үе тэнгийнхний харилцаа, харин багшийн үнэлгээгээр хөвгүүдэд зан үйл нь тус тус хэвийн ба хэвийн бус илрэлийн хооронд (заагт) байгаа нь статистик ач холбогдол бүхий хамааралтай байлаа.

Өмнөговь аймгийн өсвөр үеийнхний 41.8% нь эрүүл, 51.3% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 6.9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байна.

Өсвөр үеийнхний сэтгэл санааны байдалд гол нөлөөлж буй хүчин зүйлд “Дааврын өөрчлөлт” нь багш (36.0%) болон эцэг эх/асран хамгаалагчийн (21.4%) үнэлгээгээр хамгийн өндөр хувиар давхцаж байна. Мөн “Үе тэнгийнхний дарамт шахалт” нөлөөлдөг гэж эцэг эх/асран хамгаалагч (22.4%), багш нар (15.0%) харьцангуй өндөр хувьтай үнэлсэн байна. Харин багш нарын 25% нь “Эцэг эхийн хэрүүл маргаан, үл ойлголцох байдал”, 19.7% нь “Гэр бүл салалт” нөлөөлдөг гэж хариулжээ. Гэтэл хүүхдүүдийн 22.5% нь “Стрессээ тайлах арга эзэмшээгүй байх”, 19.9% нь “Ганцаардал” эрүүл мэнд ба сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлж байна гэж хариулсан байлаа.

Хүүхэд амиа хорлоход хүргэж буй шалтгааныг багш нар үнэлэхдээ 45.1% нь “Айлгаж сүрдүүлэх сэдэл”, 42.5% нь “Хайртай хүнээ алдах”, 38.3% нь “Гэмтэл бэртэл” зэрэг нь хамгийн их нөлөөлдөг гэсэн бол эцэг эх/асран хамгаалагчдын үнэлгээгээр 31.1% нь “Айлгаж сүрдүүлэх сэдэл”, 32.2% нь “Хайртай хүнээ алдах”, 33.9% нь “Гэмтэл бэртэл” зэрэг нь хамгийн их нөлөөлдөг гэж багш нартай ойролцоо үнэлсэн байлаа.

Багш, эцэг эх/асран хамгаалагчийн аль алины үнэлгээнд амиа хорлох үйлдэл хийхэд “Бүтэлгүй хайр, дурлал” нөлөөлдөг хэмээн үзсэн нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байв. Харин эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр “Хайртай нэгнээ алдах” (35.4%), “Архи, мансууруулах бодист донтох эмгэг” (33.4%), “Сүрдүүлэх, айлгах сэдлээр” (33.3%), “Улс төр, нийгмийн тогтворгүй байдал” (32.7%), “Сургуультай холбоотой зөрчил” (27.3%), “Гэр бүлийн харилцааны зөрчил”(23.6%), “Үе тэнгийнхний дарамт” (10.9%), “Гэр бүл салалт” (8.9%), “Бэлгийн харилцааны асуудал” (8.8%) нь хөвгүүдтэй харьцуулахад охидод илүүтэйгээр амиа хорлоход нөлөөлж байна гэж үзсэн нь статистик ач холбогдол бүхий байлаа.

### Дүгнэлт:

1. Өмнөговь аймгийн өсвөр үеийнхний 41.8% нь эрүүл, 51.3% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 6.9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байна.
2. Өсвөр үеийнхний сэтгэл санааны байдалд эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээгээр “Дааврын нөлөө” хамгийн их хувьтай, мөн “Үе тэнгийнхний дарамт шахалт”, “Эцэг эхийн хэрүүл маргаан, үл ойлголцох байдал”, “Гэр бүл салалт”, хүүхдийн үнэлгээгээр “Стрессээ тайлах арга эзэмшээгүй байх”, “Ганцаардал” зэрэг хүчин зүйлс илүүтэй нөлөөлж байна гэж үнэлсэн.
3. Эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээгээр амиа хорлох үйлдэл хийхэд “Бүтэлгүй хайр, дурлал” нөлөөлдөг хэмээн үзсэн. Харин эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр “Хайртай нэгнээ алдах”, “Архи, мансууруулах бодист донтох эмгэг”, “Сүрдүүлэх, айлгах сэдлээр”, “Улс төр, нийгмийн тогтворгүй байдал”, “Сургуультай холбоотой зөрчил”, “Гэр бүлийн харилцааны зөрчил”, “Үе тэнгийнхний дарамт”, “Гэр бүл салалт”, “Бэлгийн харилцааны асуудал” зэрэг нь хөвгүүдтэй харьцуулахад охидод илүү нөлөөлж болно гэж үзсэн нь статистик ач холбогдолтой байна.

## ABSTRACT

### Survey on adolescents' mental health status in Umnugovi province

**Keywords:** Emotions, Adolescent, Mental Health, Adolescent behavior

**Background:** According to estimates provided by the World Health Organization, 20 percent of children worldwide suffer from mental and behavioral disorders and most of the mental disorders started in childhood. Within the many measurements for these problems, **Strength, and Difficulties Questionnaires (SDQ)** is widely used in recent years. The World Health Organization Report Instrument for Mental Health Systems /WHO-AIMS/ 2006 highlighted that “Mongolia does not offer child and adolescence mental health services”.<sup>10</sup> Furthermore, we aimed to study common emotional and behavioral problems to introduce school-based early detecting methods of mental problems that will prevent mental disorders and identify individuals with abnormal behaviors.

**Aim:** To determine prevalence of emotional and behavioral disorder among adolescents, and to explore some attributing risk factors in Umnugovi province.

**Materials and methods:** We selected the versions for children, adolescents, their parents, and teachers of the globally accepted Strengths and Difficulties Questionnaire (SDQ) with 25 questions that the total score determines normal, borderline and abnormal ranges of emotional and behavioral problems. This a cross-sectional study covered a total of 3788 secondary schools' adolescents aged between 11 and 18 years; 3670 parents/caregivers and 172 teachers from the central and rural areas of the Umnugovi province and conducted between April to June 2019.

**Results:** A total of 1652 (43.6%), and 2136 (56.4%) out of 3788 survey participants were from the province and the soum centers accordingly. Among them, 46.8 percent (n=1774) were boys, 53.2 percent (n=2014) were girls; and an average age of 3670 parents/caregives who partake in the survey was  $40.1 \pm 9.1$ , from which 79.1 percent (n=2903) was female, 20.9 percent (n=767) was male. We gathered information from 172 teachers. Average age of the teachers was  $35.8 \pm 7.6$  and average year of teachers' work experience was  $14.2 \pm 11.1$  years and in-class teaching was  $2.46 \pm 1.6$  years.

The analysis of the parents/caregivers and teachers responses of SDQ to determine of emotional and behavioral problems showed that average score of prosocial behavior was at the normal range among boys and girls. By the teachers' and students' responses an average score of hyperactivity-inattention was at the normal range among boys and girls. However, peer relationship problems among boys and girls and conduct problems among boys were at the borderline range by the students' self-evaluation and teachers' responses accordingly, and it has statistical significance.

Regarding the survey results, 41.8 percent of the adolescents in Umnugovi province were healthy, 51.3 percent of them were with emotional and behavioral problems and 6.9 percent of them were with emotional and behavioral disorders.

Regarding to attributing risk factors to mental health status of adolescents, “Hormonal effect” were highlighted by parents/caregivers' response (36.0%) and by teachers' evaluation (21.4%) both. Also next main risk factor was “Peer pressure” by parents/caregivers' response



(22.4%) and by teachers' evaluation (15.0%). 25 percent of teachers stated "Conflicts with parents" and 19.7 percent mentioned that "Family divorce" is the attributing risk factors to mental health status of adolescents. 22.5 percent of students mentioned that "Inability to handle stress" and 19.9 percent of them listed "Loneliness" as the main risk factors affect adolescents' mental health.

In terms of defining suicidal risk factors, 45.1 percent of teachers named "To be threatened and scared", 42.5 percent of them mentioned "Loss of loved one" and 38.3 percent of them listed "Injure" as the main risk factors and 31.1 percent of parents/caregivers highlighted "To be threatened and scared", 32.2 percent of them mentioned "Loss of loved one" and 33.9 percent of them listed "Injure" as main risk factors accordingly.

Also, both teachers and parents/guardians noted that "Fail in love" contributed to suicide with statistic significance. By the view of the parents "Loss of loved one" were higher among girls (35.4%). Also parents/caregivers evaluated that, "Alcohol and drug addiction" (33.4%), "To be threatened, scared" (33.3%), "Political and social instability" (32.7%), "Conflicts related to school" (27.3%), "Family conflict" (23.6%), "Peer pressure" (10.9%), "Family divorce" (8.9%) and "Sexual problems" (8.8%) mainly contributed to suicide among girls than boys.

### **Conclusion:**

1. The survey results showed that 41.8 percent of adolescents perceived themselves as healthy, 51.3 percent of them were with emotional and behavioral problems and 6.9 percent of them were with emotional and behavioral disorders in Umnugovi province.
2. "Hormonal effect" has higher parentage in the parents/caregivers', and teachers responses followed by "Peer pressure", "Conflicts with parents and quarrel", "Parental divorce"; students assumed that "Inability to handle stress", "Loneliness" are main risk factors affecting adolescents' mental health status.
3. Both teachers and parents/guardians noted that "Fail in love" contributed to suicide with statistic significance. By the view of the parents "Loss of loved one", "Alcohol and drug addiction", "To be threatened, scared", "Political and social instability", "Conflicts related to school", "Family conflict", "Peer pressure", "Family divorce" and "Sexual problems" mainly contributed to suicide among girls than boys with statistic significance.

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

### 1.1 Судалгааны ажлын үндэслэл

Өсвөр насанд (шилжилтийн нас, бэлэг бойжилтын нас) охид, хөвгүүдэд биологи (физиологи, бие махбодын), нийгэм сэтгэлзүйн олон хувирал өөрчлөлтүүд явагддаг бөгөөд аливаа таагүй үйл явдал, тааламжгүй мэдээлэлд өөрийгөө хамгаалах өвөрмөц сэтгэлзүйн (сэтгэл хөдлөл, зан үйлийн өөрчлөлт) хариу урвал өгдөг.<sup>1</sup>

Дэлхий дээр хүүхэд, өсвөр үеийнхний 20% нь сэтгэц, зан үйлийн эмгэгтэй бөгөөд сэтгэцийн ихэнх эмгэг хүүхэд, өсвөр насанд эхлэн илэрдэг болохыг ДЭМБ-аас тогтоожээ.<sup>2,3</sup>

Түүнчлэн сургуулийн насны хүүхдийн дунд хамгийн багаар бодоход 3% нь сэтгэл гутралын хүнд хэлбэр, амиа хорлох бодол, солиорол, анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх зэрэг сэтгэцийн эмгэгтэй байна.<sup>3</sup>

ДЭМБ-ийн 2001 оны “Эрүүл мэнд”-ийн тайланд 9-17 насны хүүхдийн дунд сэтгэл түгших эмгэг 13%, зан үйлийн эмгэг 10.3%, сэтгэл хөдлөлийн эмгэг 6.2%-ийн тархалттай байгааг тогтоожээ.<sup>4</sup>

Оросын Холбооны Улсын Сибирь мужид 2007 онд хийгдсэн судалгаагаар хүүхэд өсвөр насанд сэтгэцийн тулгамдсан асуудал 15-20%-ийн тархалттай болохыг илрүүлсэн байна.<sup>5</sup>

Энэ асуудал нь хэвийн, зааг, хэвийн бус гэсэн 3 хэлбэрээр илэрдэг ба үүнийг илрүүлэх олон аргачлал байдаг. Сүүлийн үед Strengths and Difficulties Questionnaire (SDQ) буюу “Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх асуумж”-ийг олон улсад өргөн хэрэглэж байна.<sup>6</sup>

Их Британид хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийг SDQ-ийн асуумжаар илрүүлэх судалгааг 5-15 насны 10438 хүүхдэд явуулж, 70%-д нь зан үйл, хэт хөдөлгөөнтөх, сэтгэл гутрал, сэтгэл түгшилтийг илрүүлсэн байна.<sup>7</sup>

Америкийн Нэгдсэн Улс (2009), Их Британи (1999, 2000, 2014), Австрали (2001), Грек (2009), Норвеги (2011, 2014), БНСУ (2013), БНХАУ (1997, 2005, 2013), ОХУ (2007), Иран (2009, 2013), Бразил (2003), Япон (2014), Герман (2000) зэрэг 100 гаруй оронд SDQ асуумжийн судалгаа хийж, 4000 гаруй өгүүлэл хэвлэгдсэн байдаг. Америкийн Нэгдсэн Улсад нэгэн сургуульд суурилан хийгдсэн судалгаагаар 18-22% сэтгэл хөдлөл, зан үйлийн тулгамдсан асуудалтай болохыг тогтоосон байдаг.<sup>8</sup>

Мөн зан үйлийн эмгэгийн тархалт 5-20%, хөвгүүдийн 6-16%, охидын 2-9% нь зан үйлийн эмгэгтэй, хүйсний хувьд хөвгүүдэд охидыг бодвол илүү, газар нутгийн хувьд хөдөөг бодвол хотод илүү тохиолдож байна.<sup>9</sup>

Монгол Улсад ДЭМБ-аас гаргасан сэтгэцийн эрүүл мэндийн тогтолцоо (WHO-AIMS)-ны үнэлгээгээр “Хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ байхгүй байна. Цаашид хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ явуулах мэргэжлийн чадамжийг хөгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй байгааг тэмдэглэжээ.”<sup>10</sup> Иймд өсвөр үеийнхний сэтгэцийн тулгамдсан асуудлыг эрт илрүүлж, сэтгэцийн эмгэгтэй бие хүн болохоос урьдчилан сэргийлэхийн тулд сэтгэл хөдлөл, зан үйлийн судалгааг хийх зайлшгүй шаардлага бидний өмнө тулгарсан билээ.

## 1.2 Судалгааны ажлын зорилго

Өмнөговь аймгийн өсвөр үеийнхэнд зонхилон тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, тэдгээрийн тархалт, нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судлан тогтоох

### Судалгааны ажлын зорилтууд

1. Өмнөговь аймгийн өсвөр үеийнхэнд зонхилон тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, тэдгээрийн тархалтыг судлан тогтоох
2. Өмнөговь аймгийн өсвөр үеийнхэнд зонхилон тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйл өөрчлөгдөхөд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлсийг судлах

## 1.3 Судалгааны ажлын шинэлэг тал

1. Олон улсад түгээмэл хэрэглэдэг “SDQ” асуумж ашиглан Өмнөговь аймагт анх удаа сургуульд суурилсан агшингийн загвараар ЕБС-д суралцаж буй өсвөр үеийнхэнд, тэдний эцэг эх, багш нарыг хамруулан, сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлсэн.
2. Сэтгэл хөдлөл, зан үйлийн тархалт, түүнд нөлөөлж буй зарим эрсдэлт хүчин зүйлсийг судалснаар түүнээс урьдчилан сэргийлэх боломж бий болгосон.

## 1.4 Судалгааны ажлын практик ач холбогдол

1. Ерөнхий Боловсролын Сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилд эрүүл мэндийн хичээлийн хөтөлбөрт сэтгэцийн эрүүл мэнд (сэтгэл хөдлөл, зан үйл), хорт зуршлын агуулгыг оруулан судлах болсон.
2. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн ба хүүхэд, эцэг, эхчүүдэд зориулсан өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн өөрчлөлт, түүнийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж үзүүлэх гарын авлага боловсруулан хэрэглээ болгосон.
3. Өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн өөрчлөлтийг илрүүлэх, оношлох SDQ арга зүйг ЕБС ба хүүхдийн сэтгэцийн практикт нэвтрүүлж эхэлсэн.

## 1.5 Судалгааны ажлын ёс зүй

Энэхүү судалгааны ажлыг АШУҮИС-ийн Био анагаахын ёс зүйн хяналтын салбар хорооны 2012 оны 12-р сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл (№1212-10/1А) авсан.

Судалгаанд оролцогч нарт судалгааны зорилгыг нэг бүрчлэн таниулж судалгаанд өөрийн хүсэлтээр оролцох, мэдээллийг зөвхөн эрдэм шинжилгээний зорилгоор ашиглахыг тайлбарлан ойлгуулж, зөвшөөрлийн хуудсанд гарын үсгийг зуруулан баталгаажуулсны үндсэн дээр уг судалгааг явууллаа.

“Хүүхдийн сэтгэл хөдлөл зан үйлийн байдлыг үнэлэх SDQ” асуумжийг 2013 онд Монгол Улсад олон улсын стандартын дагуу монгол хэл рүү хөрвүүлэн орчуулж 2250 хүүхдийг хамруулан судалгаа хийж уг асуумжийн найдвартай байдлыг тогтоосноор монгол хүүхдийн сэтгэл хөдлөл зан үйлийн илрэлийг үнэлэхэд тохиромжтой болохыг баталгаажуулсан.

Бид судалгааны нууцлалыг хадгалах үүднээс судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн сурлагын ерөнхий үнэлгээг тухайн сургуулийн захирал болон анги удирдсан багшийн зөвшөөрлөөр зөвхөн үсгэн (A,B,C,D,F) хэлбэрээр нэр хаяггүй авч судалгаа шинжилгээний зорилгоор ашигласан. Судалгааны аливаа мэдээллийг хэвлэн нийтүүлэх үед судалгаанд хамрагдсан хүүхдүүд болон анги удирдсан багш, эцэг эх/асран хамгаалагч нарын овог нэр болон хувь хүний зөвшөөрөлгүй хувийн мэдээлэлтэй холбоотой зүйлсийг дурьдаагүй болно.

Уг судалгаанд ашигласан эх материалыг Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцаж, нууцлалыг хадгалж, 10 жил архивлана.

Судалгааны ажилд АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын Хорооны 2018 оны 01 сарын 26-ны өдрийн (№2018/Д-01) хурлын шийдвэрээр судалгааны явцад олон улсын ба манай оронд мөрдөгдөж байгаа судалгааны ажлын ёс зүйн дүрэм, журмуудыг зөрчөөгүй байна гэсэн дүгнэлтийг гаргасан.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

### 2.1 Судалгааны загвар

Тоон судалгааны агшингийн загварыг ашигласан бөгөөд судалгааны мэдээллийг 2019 оны 4-6 сарын хооронд цуглуулсан.

#### Хүснэгт 1. Судалгаанд баримталсан шалгуур үзүүлэлтүүд

Судалгаанд оролцогчдыг сонгох шалгуур	Судалгаанд оролцогчдыг хасах шалгуур
<ul style="list-style-type: none"> <li>Судалгаанд оролцохыг зөвшөөрсөн дунд, ахлах ангийн сурагч, тэдний эцэг эх/асран хамгаалагч ба анги удирдсан багш нарыг хамруулах</li> <li>Өмнөговь аймагт амьдардаг байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Дунд, ахлах ангийн сурагч, тэдний эцэг эх/асран хамгаалагч, анги удирдсан багш нар судалгаанд оролцохоос татгалзсан тохиолдолд</li> <li>Дунд, ахлах ангид суралцдаггүй бол</li> <li>Өмнөговь аймагт амьдардаггүй бол</li> </ul>

### 2.2 Судалгааны хамрах хүрээ ба түүвэр

Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс болон боловсролын газрын захиалгаар Өмнөговь аймгийн ЕБ-ын нийт 21 сургуулийг хамруулж зорилтот түүвийн аргаар 2019 оны 4-6 сард дунд болон ахлах ангид суралцаж буй нийт (n=5127) сурагчийг судалгаанд хамруулахыг зорьсон. Гэсэн хэдий ч хүүхдүүдийн эцэг эх/асран хамгаалагч судалгаанд оролцохыг зөвшөөрөөгүй, судалгааны картыг зарим хүүхэд хангалтгүй бөглөсөн зэрэг шалтгаанаар нийт 1339 хүүхдийн материал хасагдсан. Иймд судалгаанд нийт 3788 сурагчдыг хамруулсан бөгөөд үүнээс аймгийн төвөөс 1652, сумдаас 2136 хүүхэд тус тус хамрагдсан. Үүнээс гадна судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 3670 эцэг эх/асран хамгаалагч, 172 анги удирдсан багшийг оролцуулж хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг судалсан.

### 2.3 Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн

#### Судалгааны асуумж (Strengths and Difficulties Questionnaire SDQ)

Өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийг олон улсад түгээмэл хэрэглэдэг 25 асуулт бүхий “Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илрүүлэх (SDQ)” стандарт асуумжийн эцэг эх, багш, хүүхэд гэсэн 3 хувилбараар нэгэн зэрэг өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг цогцоор нь судалж эрүүл болон эмгэгийг илрүүлэх боломжтой. Бид судалгааны асуумжийн найдвартай байдлыг хангах үүднээс 2013 онд олон улсын стандартын дагуу монгол хэл рүү хөрвүүлэн орчуулж 2250 хүүхдийг хамруулан судалгаа хийж, найдвартай байдлыг тогтоосноор монгол хүүхдийн сэтгэл хөдлөл зан үйлийн байдлыг үнэлэхэд тохиромжтой болохыг баталгаажуулсан (Хүснэгт 2).

## Хүснэгт 2. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)

Асуулт бүрт “Үнэн биш”, “Заримдаа үнэн”, “Яг үнэн” гэсэн хариултуудаас аль нэгийг сонгож тэмдэглэнэ. Та өөрийнхөө хариултад бүрэн итгэлгүй байсан ч анхны сэтгэгдлээр бүх асуултанд хариулна уу. Хариулахдаа Та өөрийнхөө сүүлийн 6 сард гаргаж байгаа сэтгэл санаа, зан үйлийн талаар бодож хариулна уу.

Хүүхдийн нэр .....	Эрэгтэй/Эмэгтэй			
	Төрсөн огноо .....	Үнэн биш	Заримдаа үнэн	Яг үнэн
Би бусад хүмүүстэй сайхан харилцаатай байхыг хичээдэг.		0	1	2
Би хөдөлгөөнтэй болохоор нэг газраа удаан байж чаддаггүй.		0	1	2
Миний ихэнхдээ толгой өвддөг.		0	1	2
Би ихэнхдээ бусад хүүхдүүдтэй (тоглоом, үзэг г.м) юмаа хуваалцдаг.		0	1	2
Би дүрсхийн уурлаж, ердийн байдлаа алддаг.		0	1	2
Би ихэнхдээ ганцаараа тоглодог.		0	1	2
Би ихэнхдээ дуулгавартай байдаг.		2	1	0
Би олон зүйлд санаа зовнидог, түгшдэг.		0	1	2
Би бусдыг гэмтсэн, өвдсөн үед нь тусалдаг.		0	1	2
Би байнгын хөдөлгөөнтэй, тогтворгүй байдаг.		0	1	2
Би нэг л дотны сайн найзтай.		0	1	2
Би байнга зодолддог. Би бусдыг дарамталдаг.		0	1	2
Би ихэнхдээ аз жаргалгүй, сэтгэлээр унадаг.		0	1	2
Би ерөнхийдөө бусад хүүхдүүдэд таалагддаг.		2	1	0
Миний анхаарал амархан сарнидаг.		2	1	0
Би шинэ орчинд байхаараа сандарч түгшдэг.		0	1	2
Би бага насны хүүхдүүдэд зөөлөн ханддаг.		2	1	0
Би байнга худлаа ярьдаг, хууран мэхэлдэг.		2	1	0
Бусад хүүхдүүд намайг дарамталдаг.		0	1	2
Би ихэнхдээ бусад сайн дураараа туслахыг хичээж явдаг. (багш, эцэг, эх, бусад хүүхдүүдэд г.м)		0	1	2
Би ямар нэгэн үйлдэл хийхийн өмнө сайтар тунгаан боддог.		0	1	2
Би сургууль, гэр, хаа нэг газраас ямар нэгэн зүйлийг зөвшөөрөлгүй авч байсан.		0	1	2
Би үеийн хүүхдүүдтэй байхаасаа илүү том хүмүүстэй байх нь амар байдаг.		0	1	2
Би олон зүйлээс айдаг.		0	1	2
Би эхэлсэн ажлаа дуусгадаг.		0	1	2

Гарын үсэг .....

Огноо:.....


Эцэг/эх/багш/бусад/ (Хэн хариулснаа бичнэ үү):

Судалгааны асуумжийн 25 асуулт нь 5 бүлэгт хуваагдах ба I) сэтгэл хөдлөл (3,8,13,16,24-р асуулт), II) зан үйл (5,7,12,18,22-р асуулт), III) анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх (2,10,15,21,25-р асуулт), IV) үе тэнгийнхний харилцаа (6,11,14,19,23-р асуулт), V) нийтэч зан (1,4,9,17,20-р асуулт)-ийн илрэлийг тус тус тодорхойлдог (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)-ийн оноог тооцоолох нь**

<b>Асуултууд Үзүүлэлтүүд</b>		<b>Үнэн биш</b>	<b>Заримдаа</b>	<b>Яг үнэн</b>
<b>Сэтгэл хөдлөл</b>				
Асуулт 3	Миний толгой ихэнхдээ өвддөг.	0	1	2
Асуулт 8	Би олон зүйлд санаа зовнидог, түгшдэг.	0	1	2
Асуулт 13	Би ихэнхдээ аз жаргалгүй, сэтгэлээр унадаг.	0	1	2
Асуулт 16	Би шинэ орчинд байхаараа сандарч түгшдэг.	0	1	2
Асуулт 24	Би олон зүйлээс айдаг.	0	1	2
<b>Зан үйл</b>				
Асуулт 5	Би дүрсхийн уурлаж, ердийн байдлаа алддаг.	0	1	2
Асуулт 7	Би ихэнхдээ дуулгавартай байдаг.	2	1	0
Асуулт 12	Би байнга зодолддог. Би бусдыг дарамталдаг.	0	1	2
Асуулт 18	Би байнга худлаа ярьдаг, хууран мэхэлдэг.	0	1	2
Асуулт 22	Би сургууль, гэр, хаа нэг газраас ямар нэгэн зүйлийг зөвшөөрөлгүй авч байсан.	0	1	2
<b>Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх</b>				
Асуулт 2	Би хөдөлгөөнтэй болохоор нэг газраа удаан байж чаддаггүй.	0	1	2
Асуулт 10	Би байнгын хөдөлгөөнтэй, тогтворгүй байдаг.	0	1	2
Асуулт 15	Миний анхаарал амархан сарнидаг.	0	1	2
Асуулт 21	Би ямар нэгэн үйлдэл хийхийн өмнө сайтар тунгаан боддог.	2	1	0
Асуулт 25	Би эхэлсэн ажлаа дуусгадаг.	2	1	0
<b>Үе тэнгийнхний харилцаа</b>				
Асуулт 6	Би ихэнхдээ ганцаараа тоглодог.	0	1	2
Асуулт 11	Би нэг л дотны сайн найзтай.	2	1	0
Асуулт 14	Би ерөнхийдөө бусад хүүхдүүдэд таалагддаг.	2	1	0
Асуулт 19	Бусад хүүхдүүд намайг дарамталдаг.	0	1	2
Асуулт 23	Би үеийн хүүхдүүдтэй байхаасаа илүү том хүмүүстэй байх нь амар байдаг.	0	1	2
<b>Нийтэч зан</b>				
Асуулт 1	Би бусад хүмүүстэй сайхан харилцаатай байхыг хичээдэг.	0	1	2
Асуулт 4	Би ихэнхдээ бусад хүүхдүүдтэй (тоглоом, үзэг г.м) юмаа хуваалцдаг.	0	1	2
Асуулт 9	Би бусдыг гэмтсэн, өвдсөн үед нь тусалдаг.	0	1	2
Асуулт 17	Би бага насны хүүхдүүдэд зөөлөн ханддаг.	0	1	2
Асуулт 20	Би ихэнхдээ бусад сайн дураараа туслахыг хичээж явдаг (багш, эцэг, эх, бусад хүүхдүүдэд г.м).	0	1	2

Сэтгэл хөдлөл, зан үйл, анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх, үе тэнгийнхний харилцааны илрэл тус бүр нь 5 асуулттай, асуулт бүр 0-2 оноогоор буюу бүлэг бүр нийт 0-10 оноогоор үнэлэгдэж сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг илэрхийлдэг. Нийтэч занг илрүүлэх 5 асуулт нь харьцуулан хянах үнэлгээ болно (Зураг 1).



Зураг 1. “Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж”-ийн схем






Хүүхдийн хувилбар

#### Хүснэгт 4. Өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн талаарх ойлголт

Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал	
	<p><b>Сэтгэл хөдлөл</b> Хүн байгаль нийгмийн үзэгдэл юмсыг танин мэдээд зогсохгүй тэдгээрийн сэтгэлээрээ мэдэрч сайхан зүйлд баясах, баярлах, муухай зүйлд дургүйцэх, уурлах зэрэг хэлбэрээр хариу урвал өгөхийг хэлнэ.</p>
	<p><b>Зан үйл</b> Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс заншил, ёс суртахуун, сахилга бат буюу дэг журам, хууль ёсыг баримтлан, биеэ авч явах илрэлийг хэлнэ.</p>
	<p><b>Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх</b> Анхаарал төвлөрүүлэх чадвар сул хийгээд хэт хөдөлгөөний шинжүүдээр илрэх байдлыг хэлнэ.</p>
	<p><b>Үе тэнгийнхний харилцаа</b> Өсвөр үеийнхний хоорондын мэдээлэл хүргэх, дамжуулах, бие биетэйгээ харилцан үйлчлэх, үзэл бодол, итгэл үнэмшил, хандлагаа солилцох, хандлага төлөвшүүлэх нийгмийн үйл явцыг хэлнэ.</p>
	<p><b>Нийтэч зан</b> Нийтэч зан гэдэг нь бусдад туслах, хуваалцах, хандив өгөх, сайн дурын ажил хийх гэх мэт хүмүүст болон нийгэмд бүхэлд нь ашиг тустай нийгмийн зан үйл юм.</p>



**Хүснэгт 5. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)-ийн оноог хэвийн, зааг, хэвийн бус илрэлээр ангилсан нь**

	Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал	Судалгаанд оролцогчид	Үнэлгээний онооны илрэлүүд		
			Хэвийн	Зааг	Хэвийн бус
	Сэтгэл хөдлөл	Эцэг эх/асран хамгаалагч	0-3	4	5-10
		Багш	0-4	5	6-10
		Хүүхэд	0-5	6	7-10
	Зан үйл	Эцэг эх/асран хамгаалагч	0-2	3	4-10
		Багш	0-2	3	4-10
		Хүүхэд	0-3	4	5-10
	Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	Эцэг эх/асран хамгаалагч	0-5	6	7-10
		Багш	0-5	6	7-10
		Хүүхэд	0-5	6	7-10
	Үе тэнгийнхний харилцаа	Эцэг эх/асран хамгаалагч	0-2	3	4-10
		Багш	0-3	4	5-10
		Хүүхэд	0-3	4-5	6-10
	Нийтгэч зан	Эцэг эх/асран хамгаалагч	6-10	5	0-4
		Багш	6-10	5	0-4
		Хүүхэд	6-10	5	0-4
	<b>Нийт үзүүлэлт</b>	<b>Эцэг эх/асран хамгаалагч</b>	<b>0-13</b>	<b>14-16</b>	<b>17-40</b>
		<b>Багш</b>	<b>0-11</b>	<b>12-15</b>	<b>16-40</b>
		<b>Хүүхэд</b>	<b>0-15</b>	<b>16-19</b>	<b>20-40</b>






Сэтгэл хөдлөл, зан үйл, анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх, үе тэнгийнхний харилцааны нийлбэрээр “Нийт оноо” буюу 0-40 оноогоор үнэлэгдэнэ. Үүнд:

Эцэг эх/асран хамгаалагчийн хариултаар “Нийт оноо” 0-13, багшийн хариултаар “Нийт оноо” 0-11, хүүхдийн хариултаар “Нийт оноо” 0-15 байвал **“Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн илрэлтэй”** буюу **“Эрүүл”** гэж үнэлдэг.

Эцэг эх/асран хамгаалагчийн хариултаар “Нийт оноо” 14-16, багшийн хариултаар “Нийт оноо” 12-15, хүүхдийн хариултаар “Нийт оноо” 16-19 байвал **“Сэтгэл хөдлөл, зан үйлийн зааг илрэлтэй”** буюу **“Сэтгэцийн тулгамдсан асуудалтай”** гэж үнэлдэг.

Эцэг эх/асран хамгаалагчийн хариултаар “Нийт оноо” 17-40, багшийн хариултаар “Нийт оноо” 16-40, хүүхдийн хариултаар “Нийт оноо” 20-40 байвал **“Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус илрэлтэй”** буюу **“Сэтгэцийн тулгамдсан асуудалтай”** гэж үзсэн (Хүснэгт 5).

## Хүснэгт 6. Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус илрэл

Байдал	Хэвийн бус илрэлүүдийн онцлог
 <p>Сэтгэл хөдлөл</p>	<p>Сэтгэлийн хөдөлгөөн янз бүрийн байдлаар өөрчлөгдөн илрэхийг хэлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сэтгэл хэт цочиромтгой болох</li> <li>- Сэтгэлийн мэдээ алдах</li> <li>- Сэтгэлийн эмгэг цочирдол</li> <li>- Айдас</li> <li>- Сэтгэл түгших</li> <li>- Сэтгэл гутрах</li> <li>- Бухимдах гэх мэт</li> </ul>
 <p>Зан үйл</p>	<p>Нийтээр хүлээн зөвшөөрсөн зан үйлийн хэм хэмжээнүүдийг гажуудуулах буюу зөрчих хэлбэрээр биеэ зөв авч явж чадахгүй болохыг хэлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн буюу олон нийтийн газрын баримталдаг дотоод дүрэм зөрчих</li> <li>- Хүмүүс хоорондын харилцааны хэм хэмжээнүүдийг үл баримтлах</li> <li>- Хууль ёсыг зөрчих буюу нийгмийн эсрэг гэмт хэрэг үйлдэх</li> <li>- Архи, мансууруулах бодис, дамын наймаа, мөрийтэй тоглоом, садар самуун, нийгмийн сөрөг үзэгдэлд амархан автах</li> <li>- Сэтгэлийн цохилтыг үл тэсвэрлэх, хэт эмзэглэх, амиа хорлох оролдлого хийх, өөрийгөө гэмтээх</li> </ul>
 <p>Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх</p>	<p>Сүүлийн 6 сар болон түүнээс дээш хугацаанд анхаарал төвлөрүүлэх чадваргүй хийгээд хэт хөдөлгөөний шинжүүдээр илэрдэг сэтгэцийн эмгэг.</p>
 <p>Үе тэнгийнхний харилцаа</p>	<p>Хүүхдүүдийн хооронд хэн нэгнээ болон хэсэг бүлгийг ялгаварлан гадуурхах, ад шоо үзэх, дарамтлах, айлган сүрдүүлэх, үзэл бодол, илгэл үнэмшил өөр байх, хандлагыг үл ойшоох, найзлаж нөхөрлөхөөс татгалзах зэрэг хэвийн харилцаа өрнөж чадахгүй байх, өсвөр үеийнхний дунд тохиолдож буй томоохон харилцааны асуудал.</p>
 <p>Нийтгэч зан</p>	<p>Бусадтай нээлттэй, эелдэг дотно хандах, хайрлах, туслах, сэтгэлээсээ хандах, аливаа зүйлсээ хуваалцах зэрэг илэрхийлэл үгүй болж ганцаардмал, зожиг, хувиа хичээсэн зан төлөв гаргахыг хэлнэ.</p>

**Хүснэгт 7. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх асуумж (SDQ)-ийн  
“Орчны нөлөөллийн нэмэлт оноо”-г тооцоолох нь**

Үзүүлэлтүүд	Үгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Маш их
<b>Эцэг эх/асран хамгаалагчийн хариултаар</b>				
Энэ тайлагдаагүй стресс нь хүрээлэн буй орчинд нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Дээрхийн улмаас хүүхэд өөрөө хямардаг эсэх	0	0	1	2
Гэртээ байхад нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Найз нөхөдтэй болоход нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Анги хамт олны дунд байхад нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
<b>Багшийн хариултаар</b>				
Энэ тайлагдаагүй стресс нь хүрээлэн буй орчинд нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Найз нөхөдтэй болоход нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Анги хамт олны дунд байхад нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
<b>Хүүхдийн хариултаар</b>				
Энэ тайлагдаагүй стресс нь хүрээлэн буй орчинд нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Дээрхийн улмаас хүүхэд өөрөө хямардаг эсэх	0	0	1	2
Гэртээ байхад нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Найз нөхөдтэй болоход нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2
Анги хамт олны дунд байхад нь нөлөөлдөг эсэх	0	0	1	2

“Нэмэлт оноо” буюу “Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг үнэлэх” асуумжийн 26-33 дахь асуултаар сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус илрэл (дистресс)-ийн улмаас хүрээлэн буй орчинд нөлөөлж буй байдал, үргэлжилсэн хугацаа, хамрах хүрээг тодорхойлдог. Иймд 26 дахь асуултаас эхлэн нөлөөлөх нэмэлт асуудлыг тодруулах ба “Үгүй” гэж хариулсан тохиолдолд сэтгэл хөдлөл, зан үйлийн талаас ямар нэгэн бэрхшээл байхгүй гэж үзээд цааш асуух шаардлагагүй. Харин “Тийм” гэж хариулсан тохиолдолд үргэлжлүүлэн 33 дахь асуултыг дуустал асууна (Хүснэгт 7).

“Нэмэлт оноо” нь эцэг эх, хүүхдийн хариултаар 0-10 оноо, багшийн хариултаар 0-6 оноотой. Хэрвээ “Үгүй” гэсэн хариулт байвал 0 оноо, “Тийм” гэсэн бол 1-ээс дээш оноотой байх ба энэ байдал ямар хугацаагаар үргэлжилсэн эсэхийг асууна. 6 сар ба түүнээс дээш хугацаагаар үргэлжилсэн бол “Сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг” гэж үзнэ.

Асуумжаар “Сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг” хэмээн үнэлэгдсэн бол гэр бүлийн хүрээгээр хязгаарлагдсан, нийгэмшээгүй буюу өөр лүүгээ хандсан хүрээгээр хязгаарлагдсан эсвэл нийгэмшсэн буюу найз нөхөд, хамт олон, бүлгийн хүрээгээр хязгаарлагдсан эсэхийг тогтооно.

## 2.4 Мэдээ, материал цуглуулсан арга

Судалгааны мэдээллийг ганцаарчилсан ярилцлага хийж, асуулгын аргаар цуглуулсан. Хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг хүүхэд, эцэг эх/асран хамгаалагч, багш нарын үнэлгээгээр тус бүр үнэлдэг олон улсын стандарт Strengths and Difficulties Questionnaire (SDQ) асуумжаар тодорхойлсон. Энэхүү асуумжийн “Монгол хувилбар”-ыг албан ёсоор баталгаажуулж 2017 оны 1 сард интернэтэд [www.SDQinfo.com](http://www.SDQinfo.com) “Mongolian version” хаягт байршуулсан.

Судалгааны өмнө Өмнөговь аймгийн 30 судлаачдад судалгааны картыг хэрхэн бөглөх, оролцогчдыг сонгох ба хасах шалгуур, ёс зүйн зөвшөөрлийг хэрхэн авах талаар 2 хоногийн сургалтыг зохион байгуулсан.

Судалгааны мэдээллийг 2019 оны 4-6 сарын хооронд цуглуулсан болно.

## 2.5 Судалгааны үр дүнгийн боловсруулалт

Судалгааны үр дүнгийн боловсруулалтыг ЕБС-ийн 3788 хүүхэд, 3670 эцэг эх/асран хамгаалагч, 172 анги удирдсан багш нарын картанд хийхдээ үзүүлэлт тус бүрээр бүлэглэн, SPSS 22.0 программд шивж орууллаа.

Судалгааны үр дүнг дескриптив аргыг ашиглаж үзүүлэлтүүдийн эзлэх хувь ба тоон утга, тархалт, дундаж, стандарт хазайлт зэргийг тооцоолж тархалтыг хэвийн эсэхийг эхэлж тодорхойлсон. Үүний дараа хамаарлыг Пеарсоны хи квадратын, бүлгүүдийн дунджийн ялгааг тооцохдоо t-тестийн аргуудыг тус тус ашиглаж сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн, зааг, хэвийн бус, эмгэгийн тархалтыг хувиар илэрхийлсэн ба p-утга 0.05-аас бага тохиолдолд статистик ач холбогдолтой.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

### 3.1 Хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүд

Бидний судалгаанд аймгийн төвийн 1652 (43.6%), сумдаас 2136 (56.4%) нийт 3788 хүүхэд хамрагдсаны 46.8% (n=1774) нь хөвгүүд, 53.2% (n=2014) нь охид байлаа.

Мөн 3670 эцэг эх/асран хамгаалагчийг хамруулсан бөгөөд тэдний дундаж нас  $40.1 \pm 9.1$  байсан бол хүйсийн хувьд 79.1% (n=2903)-ийг эмэгтэйчүүд, 20.9% (n=767)-ийг эрэгтэйчүүд эзэлж байлаа. Ам бүлийн тоог судлахад дундаж нь  $4.6 \pm 1.4$  байсан.

Бид анги удирдсан 172 багшийг судалгаандаа хамруулсан бөгөөд багш нарын дундаж нас  $35.8 \pm 7.6$ , багшийн мэргэжлээрээ ажилласан дундаж хугацаа (жилээр)  $14.2 \pm 11.1$ , тухайн ангийг удирдаж ажилласан дундаж хугацаа (жилээр)  $2.46 \pm 1.6$  тус тус байлаа.

#### Хүснэгт 8. Өсвөр үеийнхний оршин суугаа харьяаллыг хүйс, анги, сурлагын дүнтэй нь харьцуулсан үзүүлэлт, тоо болон хувиар

Хүүхдийн үзүүлэлтүүд	Аймгийн төв		Сум		Нийт	
	n	%	n	%	n	%
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	739	44.7	1035	48.4	1774	46.8
Эмэгтэй	913	55.3	1101	51.6	2014	53.2
Нийт	1652	100	2136	100	3788	100
<b>Ахлах ба дунд анги</b>						
Ахлах анги	917	55.6	1709	80.1	2626	69.3
Дунд анги	735	44.4	427	19.9	1162	30.7
Нийт	1652	100	2136	100	3788	100
<b>Сурлагын ерөнхий үнэлгээ</b>						
А үнэлгээ	201	12.4	318	14.9	519	13.8
В үнэлгээ	478	29.4	581	27.4	1059	28.2
С үнэлгээ	443	27.3	612	28.7	1055	28.1
Д үнэлгээ	395	24.3	475	22.4	870	23.3
Е үнэлгээ	107	6.6	139	6.6	246	6.6
Нийт	1624	100	2125	100	3749	100

Тайлбар: \*А үнэлгээ 90-100%, \*В үнэлгээ 80-89%, \*С үнэлгээ 70-79%, \*D үнэлгээ 60-69%, \*F үнэлгээ 50-59%

Хүснэгт 8-аас харахад судалгаанд аймгийн төв болон сумдын хүүхдүүдийг хүйсийн хувьд ойролцоо хувьтай хамруулсан байгаа хэдий ч аймгийн төв болон хөдөө сумдаас ахлах ангийн сурагчид арай илүү хамрагдсан байна.

Сурлагын дүнг судлаж үзэхэд В болон С үнэлгээтэй хүүхдүүд дийлэнх хувийг эзэлж байна.

**Хүснэгт 9. Эцэг эх/асран хамгаалагчдын хүн ам зүйн ерөнхий үзүүлэлт, тоо болон хувиар**

Эцэг эхийн үзүүлэлтүүд	Аймгийн төв		Сум		Нийт	
	п	%	п	%	п	%
<b>Хүйс</b>						
Эрэгтэй	338	21.3	429	20.7	767	20.9
Эмэгтэй	1251	78.7	1645	79.3	2896	79.1
Нийт	1589	100	2074	100	3663	100
<b>Эцэг эхийн боловсрол</b>						
Боловсролгүй	40	2.5	46	2.2	86	2.4
Бага	59	3.7	174	8.4	233	6.4
Бүрэн бус дунд	278	17.5	496	24.0	774	21.1
Бүрэн дунд	569	35.8	728	35.2	1297	35.4
Техник мэргэжил	89	5.6	121	5.8	210	5.7
Дээд	489	30.8	469	22.6	958	26.2
Магистр, доктор	65	4.1	37	1.8	102	2.8
Нийт	1589	100	2071	100	3660	100
<b>Эцэг эхийн орон сууц</b>						
Орон сууцны байшин	302	19.0	250	12.0	552	15.1
Сууцны тусдаа байшин	403	25.4	386	18.6	789	21.6
Гэрт	875	55.2	1437	69.2	2312	63.1
Асрамжинд	2	0.1	3	0.2	5	0.1
Бусад	4	0.3	0	0.0	4	0.1
Нийт	1586	100	2076	100	3662	100
<b>Эцэг эхийн гэр бүлийн байдал</b>						
Гэрлэсэн	1231	77.5	1640	78.9	2871	78.3
Огт гэрлээгүй	93	5.8	101	4.9	194	5.3
Салсан/тусдаа амьдардаг	140	8.8	149	7.2	289	7.9
Хамтран амьдрагчтай	60	3.8	101	4.9	161	4.4
Бэлэвсэн	65	4.1	85	4.1	150	4.1
Нийт	1589	100	2076	100	3665	100

Хүснэгт 9-өөс харахад судалгаанд хамрагдсан нийт эцэг эх/асран хамгаалагчдын 35.4% бүрэн дунд, 26.2% дээд боловсролтой, 6.4% бага боловсролтой, 2.4% боловсролгүй байв. Бид эцэг эх/асран хамгаалагчдын гэр бүлийн байдлыг судлахад судалгаанд хамрагдагсдын 78.3% хууль ёсны гэр бүлтэйгээ хамт амьдардаг бол 7.9% салсан, тусдаа амьдардаг гэжээ. Харин амьдрах орчны хувьд судалгаанд хамрагдагсдын 63.1% гэрт, 21.6% сууцны тусдаа байшинд, 15.1% орон сууцны байшинд амьдарч байв. Мэргэжил эзэмшилт, ажил эрхлэлтийн хувьд судалж үзэхэд эцэг эх/асран хамгаалагчдын 22.2% ямар нэг мэргэжил эзэмшээгүй байна. Харин судалгаанд хамрагдсын 19.7% хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 23.5% цалин хөлстэй ажиллагч, 20.5% төрийн албан хаагч, 21.8% мал аж ахуй эрхлэгч хүмүүс байсан бол 14.5% тодорхой эрхэлсэн ажилгүй байна.

Эцэг эх/асран хамгаалагчдын дундаж нас  $40.12 \pm 9.12$ , ам бүлийн дундаж тоо  $4.55 \pm 1.35$  байсан бөгөөд аймгийн төв, сумдын ялгаа ажиглагдсангүй.

**Хүснэгт 10. Багш нарын нас, мэргэжлээрээ ажилласан болон анги удирдсан жилийн дундаж оноог оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт**

Багшийн үзүүлэлтүүд	Аймгийн төв	Сум	Нийт
	Дундаж±СХ	Дундаж±СХ	Дундаж±СХ
Багшийн нас	38.4±7.8	33.8±6.9	35.8±7.6
Мэргэжлээрээ ажилласан жил	19.5±13.2	10.1±6.6	14.1±11.1
Тухайн анги удирдсан жил	2.6±1.6	2.4±1.6	2.5±1.5

Хүснэгт 10-аас харахад, суманд ажиллаж буй багшийн дундаж нас ба мэргэжлээрээ ажилласан жилийн дундаж нь аймгийн төвийн багш нартай харьцуулахад ялимгүй бага буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. Магадгүй энэ нь сумдаас залуу багш нар илүү хамрагдсантай холбоотой байж болох юм. Харин тухайн ангийг удирдсан жилийн дундаж үзүүлэлтүүд нь аймгийн төв, сумын багш нарын хувьд онцын ялгаагүй, ойролцоо түвшинд байна.

**Хүснэгт 11. Багш нарын нас, мэргэжлээрээ ажилласан болон анги удирдсан жилийн дундаж оноог сумдаар харуулсан үзүүлэлт**

№	Сумын нэрс	Багшийн нас	Мэргэжлээрээ ажилласан жил	Тухайн анги удирдсан жил
		Дундаж ±СХ	Дундаж ±СХ	Дундаж ±СХ
1	Баяндалай	38.8±9.1	15.7±9.6	2.9±2
2	Баян-Овоо	34.4±5.2	9.4±6.6	2.1±1.3
3	Булган	35.7±9.5	13.4±9.3	1.8±0.9
4	Гурван тэс	30.4±4.3	7.3±3.7	2.5±1.5
5	Даланзадгад	38.4±7.8	19.5±13.2	2.6±1.6
6	Мандал-Овоо	28.4±3.4	4.7±3.9	2.8±2.3
7	Манлай	33.4±1.5	11.3±1.2	2.4±1.2
8	Ноён	39.9±3.4	8.6±5.9	1.4±0.8
9	Номгон	34.1±8.6	10.5±6	1.9±0.9
10	Сэврэй	32.4±2.5	10.3±3.1	2.5±1.1
11	Ханбогд	38.8±6.5	15.7±6.4	2.9±2.5
12	Ханхонгор	38.8±6.5	15.7±6.4	2.9±2.5
13	Хүрмэн	30.4±2.8	9.6±2.5	1.4±0.5
14	Цогт-Овоо	37.6±8.3	15.2±8.8	2.6±1.1
15	Цогтцэций	32.8±5.9	8.3±4.9	2.7±1.7

Хүснэгт 11-ээс харахад судалгаанд хамрагдсан анги удирдсан багш нарын дундаж нас, мэргэжлээрээ ажилласан жил, тухайн анги удирдсан дундаж хугацааны үзүүлэлтүүд сум тус бүрт ойролцоо байгаа хэдий ч Мандал-Овоо сумын багш нарын дундаж нас бусад сумтай харьцуулахад ялимгүй залуу байсан бөгөөд мэргэжлээрээ ажилласан жил нь харьцангуй бага гэсэн ялгаа ажиглагдлаа.

### 3.2 Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, түүнд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судалсан байдал

Бид судалгаанд хамрагдагчдаас өсвөр үеийнхэнд зонхилон тохиолддог сэтгэл хөдлөл, зан үйл, анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх, үе тэнгийгнхний харилцаа, нийтэч зан үйл гэсэн 5 илрэлийг дискриптив аргаар судалсан.

#### Хүснэгт 12. Судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлын дундаж оноог хүйсээр харьцуулсан үзүүлэлт

Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал		Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Р
		Дундаж±СХ	Дундаж±СХ	Дундаж±СХ	утга
Эцэг эх/асран хамгаалагч	Сэтгэл хөдлөл	3.14±2.1	3.59±2.2	3.38±2.2	0.183
	Зан үйл	2.78±1.5	2.65±1.5	2.71±1.5	0.091
	Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	4.59±1.6	4.45±1.6	4.52±1.7	0.066
	Үе тэнгийгнхний харилцаа	3.89±1.7	3.91±1.7	3.09±1.82	0.724
	Нийтэч зан	6.71±2.0	6.98±1.9	6.84±1.7	0.022
	Нийт оноо	14.42±4.8	14.60±4.7	14.51±4.7	0.459
Багш	Сэтгэл хөдлөл	2.41±1.9	2.44±2.0	2.43±2.0	0.655
	Зан үйл	2.63±1.6	2.38±1.4	2.50±1.5	0.049
	Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	3.98±1.7	3.76±1.6	3.86±1.65	0.000
	Үе тэнгийгнхний харилцаа	3.56±1.6	3.58±1.7	3.57±1.7	0.768
	Нийтэч зан	5.94±2.3	6.42±2.4	6.19±2.4	0.002
	Нийт оноо	12.60±4.6	12.17±4.7	12.38±4.6	0.350
Өөрөө	Сэтгэл хөдлөл Өөрөө	4.11±2.0	4.91±2.1	4.53±2.1	0.070
	Зан үйл	3.12±1.7	2.83±1.6	2.96±1.7	0.055
	Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	5.04±1.6	4.89±1.5	4.96±1.5	0.026
	Үе тэнгийгнхний харилцаа	4.65±1.6	4.42±1.5	4.53±1.5	0.016
	Нийтэч зан	6.40±1.8	6.78±1.8	6.60±1.8	0.820
	Нийт оноо	16.92±4.7	17.06±4.4	17.00±4.5	0.005

Хүснэгт 12-оос харахад эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээний дундаж оноогоор нийтэч зан, тэгвэл багш болон хүүхдүүдийн үнэлгээгээр анхаарал дутмагшил-хэт хөдөлгөөнтөх нь хөвгүүд охидод аль алинд нь хэвийн илрэлтэй байв.

Хүүхдүүдийн үнэлгээгээр хөвгүүд охидод үе тэнгийгнхний харилцаа, харин багшийн үнэлгээгээр хөвгүүдэд зан үйл нь тус тус хэвийн ба хэвийн бус илрэлийн заагт байгаа нь статистик ач холбогдол бүхий хамааралтай байлаа.



**Хүснэгт 13. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлын дундаж оноог насны бүлгээр харьцуулсан үзүүлэлт**

Үзүүлэлтүүд	11-13 нас	14-15 нас	16-18 нас	Нийт
	Дундаж±СХ	Дундаж±СХ	Дундаж±СХ	
<b>Эцэг, эх/асран хамгаалагч</b>				
Сэтгэл хөдлөл	3.36±2.1	3.40±2.2	3.39±2.1	3.38±2.2
Зан үйл	2.73±1.5	2.73±1.5	2.66±1.5	2.71±1.5
Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	4.84±1.7	4.65±1.8	4.49±1.5	4.52±1.7
Үе тэнгийнхний харилцаа	3.86±1.7	3.91±1.7	3.95±1.7	3.90±1.82
Нийтэч зан	6.91±2.0	6.78±1.9	6.81±1.9	6.84±1.7
Нийт онооны үзүүлэлт	14.49±4.8	14.56±4.7	14.49±4.6	14.51±4.7
<b>Багш</b>				
Сэтгэл хөдлөл	2.65±2.1***	2.06±1.8	2.61±1.9***	2.43±2.0
Зан үйл	2.57±1.5**	2.37±1.5	2.56±1.5	2.50±1.5
Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	3.94±1.7	3.80±1.6	3.85±1.6	3.86±1.65
Үе тэнгийнхний харилцаа	3.78±1.8***	3.37±1.5**	3.57±1.6**	3.57±1.7
Нийтэч зан	6.11±2.5**	6.29±2.3	6.18±2.3	6.19±2.4
Нийт онооны үзүүлэлт	12.96±4.8	11.60±4.2***	12.59±4.7	12.38±4.6
<b>Хүүхэд</b>				
Сэтгэл хөдлөл	4.52±2.1	4.56±2.2	4.51±2.1	4.53±2.1
Зан үйл	3.21±1.7**	2.96±1.7**	2.64±1.6	2.96±1.7
Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	4.94±1.6	4.97±1.5	4.99±1.5	4.96±1.5
Үе тэнгийнхний харилцаа	4.64±1.6	4.55±1.6	4.35±1.4**	4.53±1.5
Нийтэч зан	6.49±1.8	6.60±1.7	6.75±1.8	6.60±1.8
Нийт онооны үзүүлэлт	17.32±4.7	17.05±4.6	16.51±4.1***	17.00±4.5

\*p<0.05, \*\*p<0.001, \*\*\*p<0.0001

Хүснэгт 13-аас харахад сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг эцэг эх/асран хамгаалагч, багш, хүүхдийн үнэлгээгээр эрт (11-13 нас), дунд (14-15 нас), хожуу өсвөр нас (16-18 нас) гэсэн насны бүлгээр нь харьцуулж судаллаа.

Судалгаанд хамрагдсан эцэг эх/асран хамгаалагчдын үнэлгээний дундаж оноогоор дээрх үзүүлэлтүүдэд статистик ач холбогдол бүхий ялгаатай байдал ажиглагдсангүй.

Багш нарын үнэлгээгээр хүүхдийн сэтгэл хөдлөл 11-13, 16-18 насанд, нийтэч зан 11-13 насанд хэвийн илрэлтэй харин зан үйл, үе тэнгийнхний харилцаа нь хэвийн хэвийн бус илрэлийн заагт байлаа.

Хүүхдүүдийн үнэлгээнээс үзвэл зан үйл 11-13, 14-15 насны бүлэгт хэвийн илрэлтэй байна. Түүнчлэн, 16-18 насанд үе тэнгийнхний харилцаа нь бусад насны бүлэгтэй харьцуулахад илүү өндөр байна. Үүнээс үзэхэд өсвөр үеийнхний дунд сэтгэл хөдлөл, зан үйлийн илрэл насны бүлгээсээ хамаарч харилцан адилгүй илэрч байв.

SDQ асуумжийн аргачлалд сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр 17-40 оноо, багшийн үнэлгээгээр 16-40 оноо, хүүхдийн үнэлгээгээр 20-40 оноо авсан тохиолдолд хэвийн бус илрэлтэй гэж үнэлдэг. Харин бидний судалгаанд эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээний дундаж оноо 16.2-26.6, багшийн үнэлгээний дундаж оноо 12.8-23.4, хүүхдийн үнэлгээний дундаж оноо 18.7-

28.5 байгаа нь судалгаанд хамрагдсан хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал хэвийн бус илрэлтэй байгааг илтгэх хэдий ч статистик ач холбогдол ажиглагдсангүй.

**Хүснэгт 14. Эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээний дундаж оноог хүйс, оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт**

Үзүүлэлтүүд		Нийт	Аймгийн төв	Сум
		Дундаж±СХ	Дундаж±СХ	Дундаж±СХ
Сэтгэл хөдлөл	Эрэгтэй	3.14±2.1	3.11±2.0	3.16±2.2
	Эмэгтэй	3.59±2.1	3.63±2.1	3.55±2.2
	Нийт	3.38±2.1	3.40±2.1	3.36±2.2
Зан үйл	Эрэгтэй	2.78±1.5	2.72±1.5	2.82±1.6*
	Эмэгтэй	2.65±1.5	2.70±1.6	2.60±1.4
	Нийт	2.71±1.5	2.70±1.5	2.71±1.5
Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	Эрэгтэй	4.59±1.6	4.50±1.6	4.66±1.7
	Эмэгтэй	4.44±1.6	4.34±1.5	4.53±1.6
	Нийт	4.51±1.6	4.41±1.6	4.59±1.6
Үе тэнгийнхний харилцаа	Эрэгтэй	3.89±1.7	3.73±1.7	4.01±1.7
	Эмэгтэй	3.91±1.7	3.87±1.6	3.94±1.7
	Нийт	3.90±1.7	3.81±1.7	3.97±1.7
Нийтэч зан	Эрэгтэй	6.71±2.0	6.40±2.0	6.92±2.0
	Эмэгтэй	6.95±1.9*	6.71±2.0	7.15±1.8*
	Нийт	6.84±1.9	6.58±2.0	7.04±1.9
Нийт оноо	Эрэгтэй	14.42±4.8	14.07±4.5	14.67±4.9
	Эмэгтэй	14.60±4.7	14.54±4.6	14.64±4.7
	Нийт	14.51±4.7	14.33±4.5	14.65±4.8

\*p<0.05, \*\*p<0.001, \*\*\*p<0.0001


Хүснэгт 14-өөс харахад эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээний дундаж оноогоор судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг оршин суугаа харьяаллаар нь харьцуулж харууллаа. Дүн шинжилгээгээр, сумдын хөвгүүдэд зан үйл нь хэвийн хэвийн бус илрэлийн заагт бол сумдын охидод нийтэч зан нь хөвгүүдээс илүү хэвийн илрэлтэй байна.

**Хүснэгт 15. Багшийн үнэлгээний дундаж оноог хүйс, оршин суугаа харьяаллаар нь харьцуулсан үзүүлэлт**

Үзүүлэлтүүд		Нийт	Аймгийн төв	Сум
		Дундаж±СХ	Дундаж±СХ	Дундаж±СХ
Сэтгэл хөдлөл	эрэгтэй	2.42±1.9	2.42±1.9	2.41±2.0
	эмэгтэй	2.44±2.1	2.54±2.0	2.36±1.9
	нийт	2.43±2.0	2.49±2.0	2.39±1.9
Зан үйл	эрэгтэй	2.63±1.6***	2.65±1.6*	2.61±1.5***
	эмэгтэй	2.38±1.4	2.43±1.5	2.34±1.4
	нийт	2.50±1.5	2.53±1.5	2.47±1.5
Анхаарал дутмагшил-Хэт хөдөлгөөнтөх	эрэгтэй	3.98±1.7	3.84±1.7	4.08±2.0
	эмэгтэй	3.76±1.6	3.55±1.6	3.92±1.7
	нийт	3.86±1.7	3.68±1.7	4.00±1.6
Үе тэнгийнхний харилцаа	эрэгтэй	3.57±1.6	3.60±1.7	3.54±1.5
	эмэгтэй	3.58±1.7	3.60±1.8	3.57±1.5
	нийт	3.57±1.7	3.60±1.7	3.55±1.5
Нийтэч зан	эрэгтэй	5.94±2.3*	5.46±2.2*	6.27±2.3
	эмэгтэй	6.42±2.4	5.90±2.5	6.84±2.3
	нийт	6.19±2.4	5.71±2.4	6.56±2.3
Нийт оноо	эрэгтэй	12.60±4.6	12.52±4.3*	12.66±4.7
	эмэгтэй	12.17±4.7	12.13±4.7	12.21±4.7
	нийт	12.38±4.6	12.31±4.6	12.43±4.7

\*p<0.05, \*\*p<0.001, \*\*\*p<0.0001

Хүснэгт 15-аар багшийн үнэлгээний дундаж оноогоор судалгаанд хамрагдагсдын сэтгэл хөдлөл, зан үйлийн байдлыг оршин суугаа харьяаллаар нь харуулсан. Үүнд аймаг сумдын хөвгүүдэд зан үйл, аймгийн төвийн хөвгүүдэд нийтэч зан нь хэвийн хэвийн бус илрэлийн заагт байна.



**Зураг 2. Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүд, хувиар**


Зураг 2-оос харахад сэтгэл хөдлөл зан үйлийн байдлыг нийт онооны үзүүлэлтээр эцэг эх/асран хамгаалагчийн 31.4%, хүүхдүүдийн 27.9%, багшийн 24.0% нь сэтгэл хөдлөл зан үйлийн хувьд “Хэвийн бус” байна гэж үнэлсэн бол хүүхдүүдийн 34.2%, багшийн 29.7%, эцэг эх/асран хамгаалагчийн 23.5% нь хүүхдүүдийг “Зааг” илрэлтэй байна гэж үнэлжээ. Харин багш нарын 46.2%, эцэг эх/асран хамгаалагчийн 45.1%, хүүхдүүдийн

37.9% нь судалгаанд хамрагдсан өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл зан үйлийн байдал “Хэвийн” илрэлтэй гэж үнэлсэн байлаа. Үүнээс үзэхэд сэтгэл хөдлөл зан үйлийн “Хэвийн” илрэл нь харьцангуй өндөр үзүүлэлттэй харагдаж байгаа хэдий ч “Хэвийн бус” болон “Зааг” илрэлийн үнэлэгдсэн хувь нь 50-аас илүү хувийг эзэлж байгаа нь анхаарах шаардлагатай асуудал болохыг харуулж байна.

**Хүснэгт 16. Сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус болон зааг илрэлүүд хувь хүн, нийгмийн амьдралд нь нөлөөлсөн байдал, тоо болон хувиар**

Нөлөөлөл		Эцэг эх/асран хамгаалагч		Багш		Хүүхэд	
		тийм	үгүй	тийм	үгүй	тийм	үгүй
Энэ асуудал амьдралд нь нөлөөлдөг эсэх	n	1302	2363	2773	996	2848	940
	%	35.5	64.5	73.6	26.4	75.2	24.8
Хүүхэд өөрөө хямардаг эсэх	n	780	2885	560	3209	2150	1638
	%	21.3	78.7	14.9	85.1	56.8	43.2
Гэртээ байхад нь нөлөөлдөг эсэх	n	802	2863			1065	2723
	%	21.9	78.1			28.1	71.9
Ангийн хамт олон дунд байхад нь нөлөөлдөг эсэх	n	924	2741	542	3227	1732	2056
	%	25.2	74.8	14.4	85.6	45.7	54.3
Суралцах үйл ажиллагаанд нөлөөлдөг эсэх	n			534	3235		
	%			14.2	85.8		
Чөлөөтэй байх үед нь нөлөөлдөг эсэх	n	820	2845			1586	2202
	%	22.4	77.6			41.9	58.1
Бүхий л амьдралд нь нөлөөлж, хүндрэл учруулдаг эсэх	n	646	3019	513	3256	1425	2363
	%	17.6	82.4	13.6	86.4	37.6	62.4

Хүснэгт 15-аас харахад хүүхдийн сэтгэл хөдлөл, зан үйлийн зааг буюу хэвийн бус байдал нь хувь хүн болон нийгмийн амьдралд нь хэрхэн нөлөөлж буйг асуумжийн аргаар судлахад “Энэ асуудал амьдралд нь нөлөөлдөг” гэж хүүхдүүдийн 75.2%, эцэг эх/асран хамгаалагчдын 35.5%, багш нарын 73.6% үнэлсэн нь бусад үзүүлэлтээс хамгийн өндөр хувийг эзэлж байлаа. Тиймээс цааш тодруулж судлахад хүүхдүүдийн 56.8% нь “Би өөрөө хямарч тавгүйдэг”, 45.7% нь “Ангийн хамт олон дунд байхад сөргөөр нөлөөлдөг”, 41.9% нь “Чөлөөтэй байх үед сөргөөр нөлөөлдөг” гэсэн хариултуудыг түлхүү өгсөн байлаа. Эцэг эх/асран хамгаалагчдын үнэлгээгээр 25.2% нь “Ангийн хамт олон дунд байхад сөргөөр нөлөөлдөг” гэж түлхүү хариулсан байна. Багш нарын үнэлгээгээр 14.9% нь “Хүүхэд өөрөө хямардаг”, 14.4% нь “Анги хамт олон дунд байхад сөргөөр нөлөөлдөг”, 14.2% нь “Суралцах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг” гэсэн хариултуудыг тус тус өгсөн байлаа. Мөн сэтгэл хөдлөл, зан үйлийн зааг буюу хэвийн бус байдал “Хүүхдийн бүхий л амьдралд нь нөлөөлж, хүндрэл учруулдаг” гэж хүүхдүүдийн 37.6%, эцэг эх/асран хамгаалагчдын 17.6%, багш нарын 13.6% нь үнэлсэн байлаа. Тиймээс бид сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал нь хэр хугацаагаар үргэлжилж байгааг үнэлж үзлээ.



**Зураг 3. Сэтгэл хөдлөл, зан үйлийн байдал, үргэлжилсэн хугацаа (сар, жил), хувиар**

Зураг 3-аас харахад 1-5 сарын хооронд болон 6 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн нь ойролцоо хувийг эзэлж байгаа ба үргэлжлэх хугацаа ихсэхэд тохиолдлын тоо буурсан үзүүлэлт ажиглагдсан.

Тухайлбал хүүхдүүдийн 15.2%, эцэг эх/асран хамгаалагчдын үнэлгээний 10.5%, багш нарын үнэлгээний 6.5% нь хүүхдэд сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус байдал нь 1-5 сарын хооронд үргэлжилсэн байлаа. Харин хүүхдүүдэд энэ байдал 6 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн гэж хүүхдүүдийн 11.6%, эцэг эх/асран хамгаалагчдын 8.0%, багшийн 1.1% нь хариулсан байна.

Тэгвэл АНУ-ын DSM-V ангиллын оношлогооны шалгуурт өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн хэвийн бус байдал нь 6 сараас дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд “Сэтгэл хөдлөл ба зан үйлийн эмгэг” гэж оношилдог гэсэн заалтын дагуу дээрхийг үнэлвэл Өмнөговь аймгийн ЕБС-д суралцаж байгаа 13-18 настай хүүхдүүдийн дунд өөрсдийн үнэлгээгээр 11.6%, эцэг эх/асран хамгаалагчдын үнэлгээгээр 8.0%, багш нарын үнэлгээгээр 1.1% нь “Сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг”-тэй байх боломжтой гэж үзлээ. Тодруулбал, Өмнөговь аймгийн өсвөр үеийнхний 41.8% нь эрүүл, 51.3% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 6.9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байна.

Зураг 4-өөс харахад хүүхдийн сэтгэл санааны байдалд гол нөлөөлж буй хүчин зүйлд “Дааврын өөрчлөлт” нь багш (36.0%) болон эцэг эх/асран хамгаалагчийн (21.4%) үнэлгээгээр хамгийн өндөр хувиар давхцаж байна. Мөн “Үе тэнгийнхний дарамт шахалт” нөлөөлдөг гэж эцэг эх/асран хамгаалагч (22.4%), багш нар (15.0%) харьцангуй өндөр хувьтай үнэлсэн байна. Харин багш нарын 25% нь “Эцэг эхийн хэрүүл маргаан, үл ойлголцох байдал”, 19.7% нь “Гэр бүл салалт” нөлөөлдөг гэж хариулжээ. Гэтэл хүүхдүүдийн 22.5% нь “Стрессээ тайлах арга эзэмшээгүй байх”, 19.9% нь “Ганцаардал” эрүүл мэнд ба сэтгэл санааны байдалд сөргөөр нөлөөлж байна гэж хариулсан байлаа.



Зураг 4. Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санааны байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг эцэг эх/асран хамгаалагч, багш, хүүхэд үнэлсэн үзүүлэлт, хувиар



**Зураг 5. Амиа хорлох эрсдэлийг эцэг эх/асран хамгаалагч, багш үнэлсэн үзүүлэлт, хувиар**



Зураг 5-аас харахад хүүхэд амиа хорлоход хүргэж буй шалтгааныг багш нар үнэлэхдээ 45.1% нь “Айлгаж сүрдүүлэх сэдэл”, 42.5% нь “Хайртай хүнээ алдах”, 38.3% нь “Гэмтэл бэртэл” зэрэг нь хамгийн их нөлөөлдөг гэсэн бол эцэг эх/асран хамгаалагчдын үнэлгээгээр 31.1% нь “Айлгаж сүрдүүлэх сэдэл”, 32.2% нь “Хайртай хүнээ алдах”, 33.9% нь “Гэмтэл бэртэл” зэрэг нь хамгийн их нөлөөлдөг гэж багш нартай ойролцоо үнэлсэн байна. Мөн “Цаг агаар улирлын хүчин зүйлс”, “Улс төр, нийгмийн тогтворгүй байдал”, “Архи мансууруулах бодист донтох эмгэг”, “Гэр бүлийн харилцааны зөрчил”, “Бүтэлгүй хайр дурлал” зэрэг хүчин зүйлсийг ойролцоо хувьтай үнэлсэн байна.

**Хүснэгт 17. Амиа хорлох эрсдэлийн талаарх багшийн үнэлгээг оршин суугаа харьяаллаар харьцуулсан үзүүлэлт, хувиар**

№	Амиа хорлох эрсдэлүүд (багшийн үнэлгээгээр)	Аймгийн төв ба сум			P утга
		Нийт (n=2161)	Аймгийн төв (n=249)	Сумд (n=1912)	
1.	Сүрдүүлэх, айлгах сэдлээр	45.1%	35.9%	54.3%	0.000
2.	Хайртай нэгнээ алдах	42.5%	36.9%	48.8%	0.000
3.	Улс төр, нийгмийн тогтворгүй байдал	36.3%	32.4%	41.0%	0.000
4.	Архи мансууруулах бодист донтох	29.8%	24.7%	35.2%	0.000
5.	Сургуультай холбоотой зөрчил	18.5%	22.0%	16.7%	0.000
6.	Бэлгийн харилцааны асуудал	8.6%	14.9%	4.2%	0.000
7.	Гэр бүл салалт	6.2%	8.6%	4.7%	0.000
8.	Архаг өвчин, өвдөлт	8.3%	9.9%	7.4%	0.007
9.	Ялгаварлан гадуурхалт	2.4%	3.1%	1.9%	0.013
10.	Гэр бүлийн харилцааны зөрчил	30.4%	28.9%	32.9%	0.015
11.	Ажилгүйдэл, ядуурал	16.3%	15.3%	17.8%	0.058
12.	Үе тэнгийнхний дарамт	13.0%	12.8%	13.9%	0.355
13.	Гэмтэл	38.3%	40.1%	38.8%	0.380
14.	Гэмт хэрэгт холбогдох	11.9%	12.7%	11.9%	0.461
15.	Сэтгэцийн эмгэг	8.6%	9.1%	8.7%	0.694
16.	Бүтэлгүй хайр, дурлал	27.1%	27.4%	28.2%	0.697
17.	Стрессээ тайлах чадваргүй	30.1%	30.5%	31.2%	0.704
18.	Цаг уур, улирлын хүчин зүйлс	35.7%	36.5%	36.9%	0.920

Хүснэгт 17-оос харахад багшийн үнэлгээгээр амиа хорлох үйлдэл хийхэд “Сүрдүүлэх, айлгах сэдлээр”, “Хайртай нэгнээ алдах”, “Улс төр, нийгмийн тогтворгүй байдал”, “Гэр бүлийн харилцааны зөрчил ба хүчирхийлэл”, “Архи мансууруулах бодист донтох эмгэг”, “Сургуультай холбоотой зөрчил”, “Бэлгийн харилцааны асуудал”, “Архаг өвчин, өвдөлт”, “Гэр бүл салалт”, “Ялгаварлан гадуурхалт” зэрэг хүчин зүйлс түлхүү статистик ач холбогдол бүхий нөлөөлж байна.

**Хүснэгт 18. Амиа хорлох эрсдэлийн талаарх эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээг оршин суугаа харьяаллаар харьцуулсан үзүүлэлт, хувиар**

№	Амиа хорлох эрсдэлүүд (Эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр)	Нийт (n=1808)	Аймгийн төв ба сум		Р утга
			Аймгийн төв (n=209)	Сумд (n=1599)	
1.	Бэлгийн харилцааны асуудал	7.6%	9.4%	6.16%	0.000
2.	Сургуультай холбоотой зөрчил	24.8%	27.0%	23.1%	0.007
3.	Гэмт хэрэгт холбогдох	19.7%	21.6%	18.3%	0.013
4.	Гэр бүл салалт	7.4%	8.6%	6.5%	0.016
5.	Цаг уур, улирлын хүчин зүйлс	35.0%	36.9%	33.4%	0.029
6.	Ялгаварлан гадуурхалт	3.9%	4.5%	3.5%	0.102
7.	Стрессээ тайлах чадваргүй	21.3%	22.5%	20.4%	0.119
8.	Үе тэнгийнхний дарамт	10.0%	10.7%	9.3%	0.159
9.	Гэмтэл	33.9%	35.1%	32.9%	0.167
10.	Сүрдүүлэх, айлгах сэдлээр	31.1%	30.1%	31.8%	0.276
11.	Бүтэлгүй хайр, дурлал	26.9%	27.7%	26.2%	0.304
12.	Гэр бүлийн харилцааны зөрчил	21.9%	22.4%	21.4%	0.516
13.	Сэтгэцийн эмгэг	7.0%	6.8%	7.2%	0.609
14.	Ажилгүйдэл, ядуурал	7.5%	7.2%	7.6%	0.624
15.	Улс төр, нийгмийн тогтворгүй байдал	30.6%	30.2%	30.9%	0.625
16.	Хайртай нэгнээ алдах	32.2%	32.6%	31.9%	0.687
17.	Архаг өвчин, өвдөлт	3.6%	3.5%	3.7%	0.742
18.	Архи мансууруулах бодист донтох	30.3%	30.4%	30.2%	0.884

Хүснэгт 18-аас харахад эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр амиа хорлох үйлдэл хийхэд “Цаг уур, улирлын хүчин зүйлс”, “Сургуультай холбоотой зөрчил”, “Гэмт хэрэгт холбогдох”, “Бэлгийн харилцааны асуудал”, “Гэр бүл салалт” зэрэг хүчин зүйлс түлхүү нөлөөлж байна гэжээ.

**Хүснэгт 19. Амиа хорлох эрсдэлийн талаарх эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээг хүүхдийн хүйсээр харьцуулсан үзүүлэлт, хувиар**

№	Амиа хорлох эрсдэлүүд (багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээ)	Эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээ			Багшийн үнэлгээ		
		Хүүхдийн хүйс					
		Эрэгтэй	Эмэгтэй	P утга	Эрэгтэй	Эмэгтэй	P утга
1.	Бүтэлгүй хайр, дурлал	26.4 %	29.1%	0.021	23.4%	29.8%	0.000
2.	Хайртай нэгнээ алдах	28.5 %	35.4 %	0.000	Статистик ач холбогдолгүй		
3.	Архи, мансууруулах бодист донтох эмгэг	26.6 %	33.4 %	0.000	Статистик ач холбогдолгүй		
4.	Сургуультай холбоотой зөрчил	21.9%	27.3%	0.000	Статистик ач холбогдолгүй		
5.	Гэр бүл салалт	5.7 %	8.9 %	0.000	Статистик ач холбогдолгүй		
6.	Сүрдүүлэх, айлгах сэдлээр	28.4 %	33.3 %	0.001	Статистик ач холбогдолгүй		
7.	Бэлгийн харилцааны асуудал	6.14 %	8.84 %	0.002	Статистик ач холбогдолгүй		
8.	Улс төр, нийгмийн тогтворгүй байдал	28.1 %	32.7 %	0.003	Статистик ач холбогдолгүй		
9.	Гэр бүлийн харилцааны зөрчил	19.8 %	23.6 %	0.005	Статистик ач холбогдолгүй		
10.	Үе тэнгийнхний дарамт	8.8%	10.9%	0.026	Статистик ач холбогдолгүй		

Хүснэгт 19-өөс харахад багш, эцэг эх/асран хамгаалагчийн аль алины үнэлгээнд амиа хорлох үйлдэл хийхэд “Бүтэлгүй хайр, дурлал” нөлөөлдөг хэмээн үзсэн нь статистик ач холбогдолтой байлаа. Харин эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр “Хайртай нэгнээ алдах”, “Архи, мансууруулах бодист донтох эмгэг”, “Сүрдүүлэх, айлгах сэдлээр”, “Улс төр, нийгмийн тогтворгүй байдал”, “Сургуультай холбоотой зөрчил” “Гэр бүлийн харилцааны зөрчил”, “Үе тэнгийнхний дарамт”, “Гэр бүл салалт”, “Бэлгийн харилцааны асуудал” зэрэг нь хөвгүүдтэй харьцуулахад охидод илүүтэйгээр амиа хорлоход нөлөөлж байна гэж үзсэн нь статистик ач холбогдолтой байна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЭЛЦЭМЖ

Эрүүл Мэндийн Яамны харьяа Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв нь Эрүүл мэндийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр 2013 онд “Хүн амын дунд зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалт”-ын судалгааны ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд сургуульд суурилсан “Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн судалгааг”-г орон нутгаас 10 аймаг, Улаанбаатараас 7 дүүрэг нийт 72 сургуулийг хамруулан 2250 хүүхэд, 2250 эцэг эх, 72 багшаас мэдээллийг цуглуулсан. Судалгааны дүнд 60.5% нь эрүүл, 30.5% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байлаа. Сэтгэцийн тулгамдсан асуудал, сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг үүсэхэд гэр бүлийн бүтэц, гэр бүлийн архидалт, эцэг эх нь хүүхэдтэйгээ хамт амьдрахгүй байгаа нь нөлөөлж байна гэж дүгнэсэн. Харин 2018 онд Говь-Алтай аймагт хийгдсэн судалгаанд 58.6% нь эрүүл, 36.1% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 5.2% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байлаа. Бид дээрх судалгаануудын үр дүнтэй Өмнөговь аймгийн үр дүнг харьцуулахад сэтгэцийн тулгамдсан асуудал нь улсын дунджаас 20.8%-иар, Говь-Алтай аймгийн үзүүлэлтээс 19.7%-иар илүү байгаа бол сэтгэл хөдлөл зан үйлийн эмгэг нь улсын дундажаас 2.1%-иар бага, Говь-Алтай аймгийн үзүүлэлтээс 1.7%-иар илүү байна.

Цаашид сэтгэцийн тулгамдсан асуудал нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэг болох магадлал өндөр байдаг тул нөлөөлж буй хүчин зүйлсийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх нь сургуульд суурилсан сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөрийг боловсруулах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байгааг Өмнөговь аймагт хийсэн судалгаа нь харуулж байна. Сэтгэцийн тулгамдсан асуудал үүсэхэд өсвөр үеийнхний хоорондын хэвийн бус харилцаа маш чухал нөлөөтэй байгаа нь эцэг эх, багшийн хариултаас харагдаж байгаа ба үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхах байдал, бүтэлгүй хайр дурлал, архи, тамхи, мансууруулах бодис хэтрүүлэн хэрэглэх, архаг өвчтэй байх, гэр бүлийн орчин зэрэг нь эрсдэлт хүчин зүйлс болж байна.

## СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

1. Өмнөговь аймгийн өсвөр үеийнхний 41.8% нь эрүүл, 51.3% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 6.9% нь сэтгэл хөдлөл, зан үйлийн эмгэгтэй байна.
2. Өсвөр үеийнхний сэтгэл санааны байдалд эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээгээр “Дааврын нөлөө” хамгийн их хувьтай, мөн “Үе тэнгийнхний дарамт шахалт”, “Эцэг эхийн хэрүүл маргаан, үл ойлголцох байдал”, “Гэр бүл салалт”, хүүхдийн үнэлгээгээр “Стрессээ тайлах арга эзэмшээгүй байх”, “Ганцаардал” зэрэг хүчин зүйлс илүүтэй нөлөөлж байна гэж үнэлсэн.
3. Эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээгээр амиа хорлох үйлдэл хийхэд “Бүтэлгүй хайр, дурлал” нөлөөлдөг хэмээн үзсэн. Харин эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр “Хайртай нэгнээ алдах”, “Архи, мансууруулах бодист донтох эмгэг”, “Сүрдүүлэх, айлгах сэдлээр”, “Улс төр, нийгмийн тогтворгүй байдал”, “Сургуультай холбоотой зөрчил” “Гэр бүлийн харилцааны зөрчил”, “Үе тэнгийнхний дарамт”, “Гэр бүл салалт”, “Бэлгийн харилцааны асуудал” хөвгүүдтэй харьцуулахад охидод илүү нөлөөлж байна гэж үзсэн нь статистик ач холбогдолтой байна.

## ЗӨВЛӨМЖ

1. ЕБС-ийн эрүүл мэндийн хичээл заадаг багш нарыг сургагч багшаар сургах
2. Эцэг, эхэд /хамт олон/ СЭМ-ийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах
3. ЕБС-иудад “СЭМ-ийг дэмжих баг” байгуулах /Сургуулийн менежер, багш, өсвөр үеийн эмч, сургуулийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн/
4. ЕБС-иудад “СЭМ-ийг дэмжигч ээлтэй байгууллага” уралдаан зарлаж, урамшуулах
5. Мэргэжлийн сэтгэлзүйчийг ЕБС-д ажиллуулах
6. Сэтгэцийн эрүүл мэндийн талаарх сургалтыг тусгайлан төлөвлөгөө гаргаж, үе шаттай, тасралтгүй, нэг удаад 3-5 хоногоор зохион байгуулах. Үүнд: дараах агуулгыг заавал багтаах
  - Өсвөр үеийнхний онцлог ба үе тэнгийнхэн
  - Харилцааны ур чадварт суралцах
  - Стресс тайлах ур чадварт суралцах
  - Хорт зуршлын талаарх ойлголт, хандлагыг зөв төлөвшүүлэх
  - Сэтгэл гутрал, амиа хорлолтын талаар зөв ойлголтыг тусгайлан оруулах
  - Гэр бүлийн орчин

### Өсвөр үеийнхэнд:

1. Өсвөр үеийнхнийг стрессээ зөв аргаар тайлах ур чадварт сургах
2. Хүрээлэн буй орчин (гэр бүл, сургууль, найз нөхөд г.м)-доо эрүүл зөв харилцаа, таатай уур амьсгалыг бий болгоход анхаарал хандуулах
3. Компьютерийг удаан хугацаагаар тоглох, худал ярих, хулгай хийх, зодоон хийх, сэтгэлээр унаж гуниглах, сэтгэл түгших, анхаарал тогтворгүй байх, нойр хямрах, толгой өвдөх, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэх нь сэтгэцийн эмгэгээр өвчлөх эрсдэлтэй гэдгийг ойлгуулах

### Гэр бүл, эцэг эхийн түвшинд:

1. Сэтгэл санааны хямралтай үед гэр бүлийн гишүүд бүгд хамтдаа асуудлыг шийдвэрлэж, бусаддаа сэтгэл санааны дэмжлэг өгдөг байх
2. Гэр бүлийн хүрээнд эцэг, эхийн архидалт, ялангуяа эхийн архидалт, гэр бүлийн салалт, эцэг эх нь хүүхэдтэйгээ хамт амьдрахгүй байх асуудлыг шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах
3. Өсвөр үеийнхний тамхи татах, сурлагын дүн шалтгаангүй буурах, гэрээсээ зугтах, зайлсхийх гадуур зорилгогүй тэнэх зэрэг эрсдэлт хүчин зүйлс ажиглагдвал хүүхдийн сэтгэцийн мэргэжлийн эмчээс зөвлөгөө авах

### Аймгийн БСУГ, ЕБС-ийн түвшинд:

1. Сургуульд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, сэтгэл заслын тусгайлсан өрөөтэй болох, сэтгэлзүйч ажиллуулах
2. Сэтгэл хөдлөл, зан үйлийг илрүүлэх SDQ асуумжийг боловсролын салбарт өргөн хэрэглэж, хэвийн бус байдал 6 сар түүнээс дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд хүүхдийн сэтгэцийн мэргэжлийн эмчид хандах

3. Өсвөр үеийнхнийг чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх дугуйлан, клубыг олноор нь ажиллуулах
4. Сурагчдын дунд үе тэнгийнхний хүчирхийллийг бууруулах арга хэмжээ зохион байгуулах.
5. Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийг сургууль бүрд байгуулж сртесс тайлах ур чадварт хүүхдийг сргах

**Аймаг, сумдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний түвшинд:**

1. Аймгийн төвийн хороо, өрх, сумдын эмч нар бие махбод, сэтгэц нийгмийн тулгамдсан асуудлыг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх, урьдчилан сэргийлэх ба дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах
2. Гэр бүл болж байгаа залуу эцэг эхчүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг аймгийн төвийн хороо, өрх, сумд бүрийн эмч нар, сэтгэц-наркологиин ба эмэгтэйчүүдийн эмч нар хамтран тус тус зохион байгуулах
3. Сэтгэл хөдлөл, зан үйлийг илрүүлэн оношлох SDQ асуумжийг анхан ба 2 дахь шат, бусад эрүүл мэндийн салбарт өргөн хэрэглэж, хэвийн бус байдал 6 сар түүнээс дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд хүүхдийн сэтгэцийн мэргэжлийн эмчид хандах



**Аймгийн ЗДТГ-ын түвшинд:**

1. ЕБС-иудад ажиллаж байгаа дэмжих баг, өрх, сумын эмч нар, аймаг дүүргийн ЭМГ-ын өсвөр үеийн эмч нарыг тасралтгүй сургахад анхаарал хандуулан, дэмжлэг үзүүлж ажиллах
2. Хэвлэл мэдээллийн байгууллагууд зөв зохистой мэдээлэл өгөх замаар сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд олон нийтийн оролцоог дэмжих
3. Өсвөр насны охидод сэтгэл хөдлөл, хөвгүүдэд зан үйлийг нь засахад чиглэгдсэн сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг сургуулийн өмнөх боловсролоос эхлэхэд онцгойлон анхаарч, дэмжлэг үзүүлэн ажиллах
4. Сургуульд сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг дэмжих сургалтын менежер, багш, нийгмийн ажилтан, сургуулийн эмчээс бүрдсэн баг ажиллуулахад дэмжлэг үзүүлэх
5. БСШУСЯ, ЭМЯ-ны хамтарсан 2018 оны 12 сарын 04-ний өдрийн А494/А761 тоот тушаалыг мөрдөж ажиллах
6. Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гарын авлага эцэг эхчүүд, ЕБС-ийн багш нар, өсвөр үеийнхэнд гэсэн зорилтот бүлгээр нь боловсруулахад дэмжлэг үзүүлэх
7. ЕБС-ийн эрүүл мэндийн хичээл заах багш нарт зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн хичээлийн арга зүйн сургалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

**НОМ ЗҮЙ**

1. Бямбасүрэн С. *Сэтгэцийн эмгэг судлал*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс ХХК; 2013.
2. Organization WH, Association WP, Child IAf, Psychiatry A, Professions A. *Atlas: child and adolescent mental health resources: global concerns, implications for the future*. World Health Organization; 2005.
3. Kieling C, Baker-Henningham H, Belfer M, et al. Child and adolescent mental health worldwide: evidence for action. *The Lancet*. 2011;378(9801):1515-1525.
4. Organization WH. *The World Health Report 2001: Mental health: new understanding, new hope*. World Health Organization; 2001.
5. Slobodskaya HR, Akhmetova OA, Ryabichenko TI. Siberian child and adolescent mental health: Prevalence estimates and psychosocial factors. *Alaska medicine*. 2007;49(2):261.
6. Гудман Р, Скотт С. *Детская психиатрия*. Vol 2. Москва: Издательство "Триада-Х"; 2008.
7. Meltzer H, Gatward R, Goodman R, Ford T. *The mental health of children and adolescents in Great Britain*. HM Stationery Office; 2000.
8. Merikangas KR, Nakamura EF, Kessler RC. Epidemiology of mental disorders in children and adolescents. *Dialogues in clinical neuroscience*. 2009;11(1):7.
9. Perou R, Bitsko RH, Blumberg SJ, et al. Mental health surveillance among children-United States, 2005–2011. *MMWR Surveill Summ*. 2013;62(Suppl 2):1-35.
10. WHO MCO, WHO ROftWP, Abuse WDoMHaS. *WHO-AIMS report on Mental Health System in Mongolia*, Ulaanbaatar: World Health Organization; 2006.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ, ЗАН ҮЙЛИЙН БАЙДЛЫГ СУМДААР ХАРЬЦУУЛЖ СУДАЛСАН ДҮН**




**Зураг 1. Багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлсэн сэтгэл хөдлөл зан үйлийн нийт онооны үзүүлэлтийг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**




Зураг 1-ээс харахад эцэг эх/асран хамгаалагч, багшийн үнэлгээгээр хэвийн бус илрэлтэй (сэтгэцийн тулгамдсан асуудал) хүүхдүүд Даланзадгад (n=474, n=1148) буюу аймгийн төв нь сумдаас илүү байдаг бөгөөд Цогтцэций (n=261, n=490), Ханбогд (n=105, n=293), Гурвантэс (n=57, n=151) зэрэг хүн амын нягтрал, шилжилт хөдөлгөөн ихтэй, уул уурхай ажилладаг сумдад бусад сумдаас илүү өндөр байгаа хэдий ч сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг хувиар илэрхийлж үзвэл эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Ноён (45.0%), Цогтцэций (37.5%), Сэврэй (36.1%), багшийн үнэлгээгээр Ноён (90.0%), Манлай (96.9%), Сэврэй (91.6%) зэрэг сумдад тэргүүлж байна. Мөн Өмнөговь аймгийн бүх сумын анги удирдсан багш нар сурагчдынхаа 40 болон түүнээс дээш хувийг сэтгэл хөдлөл зан үйлийн хувьд хэвийн бус байна гэж үнэлжээ. Мөн анги удирдсан багшийн үнэлгээгээр Ноён, Мандал-Овоо, Сэврэй зэрэг сумдад сэтгэл хөдлөл зан үйлийн хувьд эрүүл хүүхэд огт байхгүй гэж үнэлсэн нь анги удирдсан багш нарын сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Харин хүүхдийн үнэлгээгээр хэвийн бус илрэлд Даланзадгад (n=398) буюу аймгийн төв нь сумдаас өндөр үзүүлэлттэй ба Цогтцэций (n=207), Ханбогд (n=126), Гурвантэс (n=69) сумдад хэвийн бус илрэл нь бусад сумдаас арай илүү байна. Харин сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг хувиар илэрхийлж үзвэл хүүхдийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Сэврэй (45.8%), Гурвантэс (37.3%) зэрэг сумдад тэргүүлж байна (Зураг 2).




**Зураг 2. Хүүхдийн өөрийн үнэлсэн сэтгэл хөдлөл зан үйлийн нийт онооны үзүүлэлтийг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**




Зураг 3. Багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлсэн сэтгэл хөдлөлийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар

Зураг 3-аас харахад эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр сэтгэл хөдлөлийн хэвийн бус илрэл Даланзадгад (n=463), Цогтцэций (n=204), Ханбогд (n=107) сумдад бусад сумдаас арай илүү илэрсэн хэдий ч сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг хувиар илэрхийлж үзвэл эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Ноён (40.0%), Мандал-Овоо (39.2%), Баяндалай (34.6%), багшийн үнэлгээгээр Мандал-Овоо (28.2%), Сэврэй (14.5%), Ханбогд (10.9%), Хүрмэн (10.8%) зэрэг сумдад тэргүүлж байна.

Хүүхдүүд өөрсдийн үнэлгээгээр сэтгэл хөдлөлийн хэвийн бус илрэл Даланзадгад (n=266), Цогтцэций (n=136), Ханбогд (n=88) сумдад бусад сумдаас арай илүү илэрсэн нь харагдаж байгаа хэдий ч сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг хувиар илэрхийлж үзвэл хүүхдийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувиар Сэврэй (25.3%), Ноён (25.0%), Ханбогд (22.8%) зэрэг сумд тэргүүлж байна (Зураг 4).




Зураг 4. Хүүхдийн өөрийн үнэлсэн сэтгэл хөдлөлийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар





**Зураг 5. Багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлсэн зан үйлийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**

Зураг 5-аас харахад эцэг эх/асран хамгаалагч болон анги удирдсан багш нарын үнэлгээгээр зан үйлийн хэвийн бус илрэл Даланзадгад (n=356, n=351), Цогтцэций (n=149, n=216), Ханбогд (n=60, n=78) суманд зонхилж байгаа бол хүүхдүүдийн өөрсдийн үнэлгээнд (Зураг 6) мөн Даланзадгад (n=227), Цогтцэций (n=140), Ханбогд (n=77) суманд зан үйлийн хэвийн бус илрэл арай илүү гэж үнэлжээ. Харин сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг нь хувиар илэрхийлж үзвэл эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Ноён (37.5%), Булган (30.5%), Хүрмэн (30.0%), багшийн үнэлгээгээр Ноён (40.0%), Мандал-Овоо (31.3%), Цогтцэций (31.3%), Сэврэй (30.1%), хүүхдийн үнэлгээгээр (Зураг 6) Ноён (32.5%), Сэврэй (26.5%), Хүрмэн (29.7%) зэрэг сумд тэргүүлж байна.




Зураг 6. Хүүхдийн өөрийн үнэлсэн зан үйлийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар




Зураг 7. Багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлсэн анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх (АДХХ) байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар

Зураг 7-оос харахад анги удирдсан багш болон эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр АДХХ байдал ерөнхийдөө өсвөр насанд бага тохиолддог гэдэг нь харагдаж байгаа ч Даланзадгад арай илүү илэрсэн байна. Харин хүүхдийн үнэлгээгээр Даланзадгад (n=208), Цогтцэций (n=107), Ханбогд (n=50), Гурвантэс (n=46) сумдад АДХХ хэвийн бус илрэл нь бусад сумдаас илүү байлаа. Түүнчлэн сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг нь хувиар илэрхийлж үзвэл эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Ноён (20.0%), Номгон (16.3%) багшийн үнэлгээгээр Булган (20.7%), Мандал-Овоо (18.8%), хүүхдийн үнэлгээгээр Гурвантэс (24.9%), Манлай (21.7%), Сэврэй (19.3%) зэрэг сумд тэргүүлж байна (Зураг 8).




**Зураг 8. Хүүхдийн өөрийн үнэлсэн анхаарал дутмагшил, хэт хөдөлгөөнтөх байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**






**Зураг 9. Багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлсэн үе тэнгийнхний харилцааны байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**

Зураг 9-өөс харахад анги удирдсан багш болон эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр үе тэнгийнхний харилцаа нь өсвөр үеийнхний гол тулгамдсан асуудал болох нь харагдаж байгаа бөгөөд бүх сумдад хэвийн бус харилцаа ноёлж байгаа ч Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс, Ханхонгор, Номгон, Цогт-Овоо, Мандал-Овоо зэрэг сум бусад сумдаас илүү байв. Харин сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг нь хувиар илэрхийлж үзвэл эцэг эх, асран хамгаалагчийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Ноён (70.0%), Мандал-Овоо (66.7%), Цогт-Овоо (65.4%), багшийн үнэлгээгээр Мандал-Овоо (50.0%), Гурвантэс (45.4%), Сэврэй (41.0%) тус тус тэргүүлж байгаа бол эцэг эх/асран хамгаалагч нарын 50-аас дээш хувь нь хүүхдүүдийн үе тэнгийнхний харилцаа асуудалтай байна гэж үнэлсэн байна. Харин үе тэнгийнхний харилцааны хувьд өөрсдийгөө зааг байдалд байна гэж бүх хүүхдүүдийн 35-аас дээш хувь нь үнэлсэн байгаа ч Номгон (39.5%), Ноён (35.0%), Ханхонгор (32.6%) зэрэг сум нь үе тэнгийнхний харилцаа хэвийн бус гэж хариулсан хариулт тэргүүлж байна (Зураг 10).




**Зураг 10. Хүүхдийн өөрийн үнэлсэн үе тэнгийнхний харилцааны байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**



Зураг 11. Багш, эцэг эх/асран хамгаалагчийн үнэлсэн нийтэч зан үйлийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар

Зураг 11 ба 12-оос харахад анги удирдсан багш, хүүхэд болон эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр нийтэч зангийн хувьд өсвөр насныхан орчиндоо нийцтэй байж чаддаг гэсэн бол Даланзадгад, Цогтцэций, Ханбогд сумын багш нар бусадтай нийцгүй байх хэвийн бус зан зонхилж байна гэж хариулжээ. Харин сум тус бүрээр судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн дунд хэвийн, зааг, хэвийн бус илрэлийг нь хувиар илэрхийлж үзвэл эцэг эх/асран хамгаалагчийн үнэлгээгээр хэвийн бус илрэлийн эзлэх хувь Цогт-Овоо (22.2%), Номгон (17.4%), Баяндалай (17.3%), багшийн үнэлгээгээр Даланзадгад (30.5%), Булган (25.6%), Баяндалай (23.5%), хүүхдийн үнэлгээгээр Булган (15.8%), Баяндалай (15.2%), Номгон (15.1%) зэрэг сумд тэргүүлж байна.



**Зураг 12. Хүүхдийн өөрийн үнэлсэн нийтэч зан үйлийн байдлыг хэвийн, зааг, хэвийн бус илрэлүүдэд хувааж сумдаар нарийвчлан судалсан үзүүлэлт, тоо болон хувиар**